

Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга **Сурвалж бичиг**



2005 оны 3 дугаар сар



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян Гүний гудамж – 5/1, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар -48, Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

Энэхүү номын монгол орчуулгыг Нээлттэй Нийгэм
Форумаас эрхлэн гаргасан ба монгол орчуулгын зохиогчийн
эрхийг Нээлттэй Нийгэм Форум эзэмшинэ.
© 2005

Орчуулсан:

Д. Наран

Хянан тохиолдуулсан:

Г. Батбаяр
Н. Дорждарь
Ц. Гомбосүрэн
С. Одхүү

Энэхүү сурвалж бичгийг Их Британийн Олон улсын хөгжлийн департамент (ОУХД)-ын Олон улсын ОСИТБС-ын нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэн гаргав. Сурвалж бичгийг цаашид туршлага хуримтлагдахын хэрээр шинэчлэн баяжуулах болно. Нэмэлт мэдээллийг eiti@dfid.gov.uk и-мэйлээр дамжуулан ОУХД-аас, мөн ОСИТБС-ын www.eitransparency.org вэб хуудаснаас авах боломжтой.

ISBN:

Агуулга

Танилцуулга	2
Бүлэг 1: ОСИТБС-ын зарчим ба шалгуурууд	4
ОСИТБС-ын тухай	4
ОСИТБС-д оролцогч талууд	5
ОСИТБС-ын зарчмууд	7
ОСИТБС-ын шалгуурууд	9
Бүлэг 2: Нөөц баялаг ихтэй орнуудад зориулсан заавар удирдамж	10
Ерөнхий тойм	10
Хэрэгжилтийн үе шатууд	10
Санал болгох нэмэлт арга хэмжээнүүдийн хураангуй	12
Эхлэл	17
А. Элсэн орох	17
Б. Үүсгэн байгуулах	19
В. Үйл явцын өрнөлт	23
Хэрэгжүүлэлт	26
Г. Ил тод болгох ба хэвлэн нийтлэх	26
Д. Олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх	34
ОСИТБС-ын хэрэгжилтийг үнэлж дүгнэх	36
Е. Үнэлэлт дүгнэлт	36
БҮЛЭГ 3: Олборлох салбарын компаниудад зориулсан заавар удирдамж	38
Ерөнхий тойм	38
Компанийн үйл ажиллагаа болон нэмэлт арга хэмжээний хураангуй	38
Баталгаажуулалт	41
А. Гарын үсэг зуран элсэх	41
Б. Олон улсын дэмжлэг	42
Үндэсний хэмжээний дэмжлэг	42
В1. Хэрэгжүүлэгч улс	43
В2. Хэрэгжүүлэгч бус орон	45
Нэр томъёоны тайлбар	46
Хавсралт	49
Тайлангийн маягтын жишээнүүд	49

Танилцуулга

ОСИТБС гэж юу вэ?

Олон улс оронд газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас олсон мөнгө нь ядуурал, зөрчил, авилгатай холбоотой байдаг. Нийтээрээ “нөөц баялгийн хяслан” гэж нэрлэдэг ийм байдал компаниудаас засгийн газарт төлж байгаа төлбөр болон тэдгээр компаниудаас засгийн газрын авч байгаа орлогын эргэн тойронд ил тод, хариуцлагатай байдал үгүйлэгдэж байдгаас гол төлөв улбаалдаг. Олборлох салбарын ил тод байдлын санаачилга (ОСИТБС) нь тэрхүү үгүйлэгдэж байгаа ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох зорилготой юм. Энэ нь компаниуд, засгийн газрууд, хөрөнгө оруулагчид, болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын дэмжлэг хүлээсэн сайн дурын санаачилга юм. ОСИТБС нь засгийн газрын төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн бусад хүчин чармайлтуудын зэрэгцээ засгийн газар тэдгээр орлогыг хэрхэн зарцуулсныхаа хариуцлагыг иргэдийн өмнө хүлээдэг болгох үйл явцыг эхлүүлдэг юм.

Ил тод байдал ба хөгжил: Сан Томе Принсипе-гийн жишээ

Сан Томе Принсипе нь Африкийн газрын тос шинээр олборлогчдын нэг юм. Өнөөдөр энд хүн амын ихэнх нь ядуу амьдардаг. Гэвч засгийн газар нь ил тодоор зохицуулж чадвал газрын тос олборлолт ард түмний амьдралд ихээхэн өөрчлөлт авчрах боломжтой гэдгийг мэдсэн юм. 2004 оны 12 дугаар сард Ерөнхийлөгч Фрадику Менезес тус орны эдийн засаг, нийгмийн дэвшлийг дээд зэргээр хөхиүлэн дэмжих зорилгоор газрын тосны төлбөрийг хүлээн авах, хөрөнгө оруулах, зарцуулах явдлыг зохицуулсан нэгэн хуулинд гарын үсэг зурсан. Энэ хуулиар уг санд орж ирж буй бүх төрлийн төлбөрийн тухай мэдээллийг олон нийт олж авах эрхтэй болсон. Ерөнхийлөгч гарын үсэг зурахдаа “Юуг ч нууж хаахгүй, юуг ч дэмий үрэхгүй” гэж хэлсэн байна.

Сурвалж баримт

Энэхүү гарын авлагыг ОСИТБС-ын туршилтын шатанд хуримтлуулсан туршлага, сургамжийг үндэслэн зохиосон учраас энэ нь тус санаачилгыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй улс орнууд төдийгүй түүний хэрэгжилтийг дэмжих сонирхолтой компаниуд, бусад оролцогчдод туслах заавар удирдамж болох юм.

Нэгдүгээр бүлэгт 2002 онд Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Чуулга Уулзалт дээр танилцуулснаас эхлээд туршилтын шат (2003 оны 6 дугаар сараас 2005 оны 3 дугаар сарыг хамарсан)-ыг дамжин өнөөгийн хэрэгжилтийн

шат хүртэлх (2005 оны 3 дугаар сараас эхэлсэн) ОСИТБС-ын хөгжлийн товч тодорхойлолтыг өгөх болно. Мөн уг бүлэгт ОСИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцож буй бүх улс орнуудад зориулсан ОСИТБС-ын гол цөм болсон зарчим, шалгууруудыг тодотгон гаргажээ.

Хоёрдугаар бүлэгт туршилтын шатанд улс орнуудын авч хэрэгжүүлсэн, ОСИТБС-ын зарчим, шалгууруудад нийцсэн, мөн түүнчлэн тухайн орны өвөрмөц онцлогийг тусгасан арга хэмжээнүүдээс жишээ болгон үзүүлэв.

Гуравдугаар бүлэгт ОСИТБС-ын хэрэгжилтийг дэмжиж байгаа компаниудын адил төстэй жишээг оруулсан болно.

Бүлэг 1

ОСИТБС-ын зарчим ба шалгуурууд

ОСИТБС-ын тухай

Газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас орох орлогоос хараат эдийн засагтай улс орнуудад ил тод, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжсэнээр орлогыг буруу зохицуулснаас үүдэж болох сөрөг нөлөөллийг багасгаж болно. Ингэснээр эдгээр орлого нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад чухал хувь нэмэртэй эдийн засгийн удаан хугацааны өсөлтөнд хүргэх чухал хөшүүрэг, хөдөлгөгч хүч болж болох юм.

Нөөц баялаг ихтэй орон гэж ямар орныг хэлэх вэ?

ОУВС-аас 2004 оны 12 дугаар сард гаргасан “Нөөц баялгаас олох орлогын ил тод байдлын журам”-ын төсөлд нүүрстөрөгч болон ашигт малтмалаар баян орнуудыг дараахь шалгуур үзүүлэлтийн үндсэн дээр тодорхойлж гаргасан. Үүнд: (i) нүүрстөрөгч болон ашигт малтмалаас төсөвт төлөх орлогын дундаж хэмжээ нь сүүлийн гурван жилийн турш нийт төсвийн орлогын дор хаяж 25 хувьтай тэнцүү байх; эсвэл (ii) нүүрстөрөгч болон ашигт малтмалын экспортын орлогын дундаж хэмжээ нь сүүлийн гурван жилийн турш нийт экспортын орлогын дор хаяж 25 хувьтай тэнцүү байсан байх гэсэн хоёр шалгуур байна.

Нөөц баялаг ихтэй орнууд, олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон дэлхийн олон нийт бүгд л ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх хүчин чармайлтыг дэмжих нийтлэг сонирхолтой байдаг. Энэ чиглэлээр олон орон ихээхэн ахиц дэвшил гаргаад байна. Эдгээр хүчин чармайлтуудыг олон улсын хамтын нийгэмлэг ч мөн дэмждэг. 2003 онд Евианд ИХ 8-ын орнууд Авилгатай Тэмцэх, Ил Тод Байдлыг Сайжруулах тунхаглал гаргасан. 2004 онд Сий Айланд хотод Ил Тод Байдлын Багцуудыг дөрвөн орон хүлээн зөвшөөрсөн. ОУВС өөрийн гишүүн орнууд дахь төсвийн ил тод байдлыг Төсвийн Ил Тод Байдлын Тэргүүн Туршлагын Код болон үүнийг дагалдах гарын авлагаараа дамжуулан дэмждэг болоод байна. Мөн энэхүү кодын хэрэгжилтийг Стандарт болон Кодуудыг Хянасан Тухай Тайланг гарган хянах болсон. ОУВС болон Дэлхийн Банкны аль аль нь нөөц баялагийн орлогын илүү үр дүнтэй удирдлагыг бодлогын зөвлөгөө, бодлогод үндэслэсэн зээллэг, төслийн зээл болон техникийн туслалцаагаар дамжуулан дэмжиж байна.

Засаглалыг сайжруулах эдгээр хүчин чармайлтуудыг дэмжих зорилгоор ОСИТБС-ыг Тони Блейр 2002 онд санаачилсан. ОСИТБС нь орлогын удирдлагын талаархи өргөн хүрээтэй ажил, хэлэлцүүлгүүд өрнөх сайн эхлэлийн цэг болж байна

ОСИТБС нь үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн олон улсын зүгээс өргөн дэмжлэгийг хүлээгээд байгаа ч уг санаачилга үндэсний түвшинд гол анхаарлаа хандуулж байна. Тухайн орны ОСИТБС-ыг өөрийн болгосон

байдал, компаниудынх нь уг санаачилгад оролцож байгаа байдал зэрэг нь олон нийтийн амьдрал, засгийн газрын болон бизнесийн үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдлын дээд зэргийн стандартууд мөрдөхийн төлөө хэр зэрэг байгааг дотооддоо болон олон улсын түвшинд харуулах дохио болж өгдөг. Санаачилгыг хэрэгжүүлэгч улсуудад ирэх ашиг тус нь засаглалыг сайжруулах өргөн хүрээтэй хүчин чармайлтуудын нэг хэсэг болж эсвэл эхлэлийн цэг болох байдлаар үндсэндээ илэрдэг. Нөөц баялагаас орох орлогын засаглалыг сайжруулах нь тэдгээр орлогын удирдлагыг илүү сайн болгоод зогсохгүй эдийн засаг, улс төрийн илүү тогтвортой байдлыг бий болгох ёстой. Түүнчлэн энэ нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарыг тойрсон аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тус дөхөм үзүүлдэг. Уг санаачилгыг хэрэгжүүлэх нь Засгийн газар ил тод байдлыг бий болгохын төлөө байна гэдэг дохиог хөрөнгө оруулагчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудад өгөх замаар хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад хувь нэмрээ оруулдаг.

Оролцогч компаниуд болон хөрөнгө оруулагчдад тусах ашиг тус нь улс төрийн болон нэр хүндтэй холбоотой эрсдлийг багасгах замаар илэрдэг. Хаалттай, ил тод бус засаглалаас үүдэн бий болсон улс төрийн тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтад илт аюул занал учруулдаг. Олборлох үйлдвэрүүдийн хувьд, хөрөнгө оруулалт нь ихээхэн хөрөнгө мөнгө шаардсан, олох ашиг нь удаан хугацааны тогтвортой байдлаас ихээхэн хамааралтай байгаа тохиолдолд улс төрийн тогтворгүй байдлыг бууруулах нь үлэмж ач холбогдолтой асуудал болдог. Ил тод байдал нь компаниудад өрсөлдөөний адил тэгш боломж олгоод зогсохгүй аливаа компани засгийн газарт төлж байгаа төлбөрөө олон нийтэд ил тод болгосноор хийж байгаа хөрөнгө оруулалтаараа улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулж байгаагаа харуулахад хэрэгтэй байдаг.

Иргэдийн нэрийн өмнөөс засгийн газрын захиран зарцуулж байгаа тэдгээр орлогын талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлж буй мэдээллийн хэмжээг нэмэгдүүлэх, улмаар засгийн газруудыг илүү их хариуцлага хүлээдэг болгоход иргэний нийгмийн хүртэх ашиг тус оршино.

ОСИТБС-д оролцогч талууд

Аливаа улс орны буюу үндэсний хэмжээнд бол ОСИТБС нь засгийн газраас гарсан санаачилга байдаг. Гэсэн хэдий ч ОСИТБС-ын зарчим ба шалгуурууд нь нийгмийн өргөн хүрээтэйгээс бусад түншүүдийг ч идэвхтэй татан оролцуулахыг шаарддаг. Үүнд өргөн хүрээтэй дотоодын манлайлал, оролцоо чухал бөгөөд янз бүрийн оролцогч талуудыг төлөөлсөн олон нийтийн идэвхтэй оролцоо шаардлагатай болно.

Оролцогч гэж ОСИТБС-аас гарах үр дүнг сонирхсон аливаа хувь хүн, иргэд, олон нийт, бүлэг, байгууллагыг хэлэх бөгөөд түүний дотор энэхүү санаачилга ямар нэгэн байдлаар (ээрэг сөрөг алин боловч) нөлөө үзүүлдэг болон үүнд ямар нэгэн байдлаар (ээрэг сөрөг аль ч байдлаар) нөлөө үзүүлж чадах хүмүүс аль аль нь орно. Оролцогчдыг төрийн байгууллага, хувийн салбар, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдүүлнэ. Санаачилгын хэрэгжилтэнд хандах сонирхлын түвшин, үзүүлж байгаа нөлөөллийнхөө байдлаас хамааран гол болон өргөн хүрээтэй оролцогчдын аль аль нь байна. Оролцогчдын ангилал нь улс орон бүрт харилцан адилгүй хэдий ч бүх улсуудад ижил төрлийн оролцогчид байх магадлалтай.

ОСИТБС-ын оролцогчдод хэнийг хамруулж болох вэ?

- Төрийн байгууллагууд
 - Гүйцэтгэх засаглалын
 - Байгалийн баялгийн удирдлага хариуцсан агентлагууд
 - Орлого бүрдүүлэлт, удирдлага хариуцсан агентлагууд
 - Эдийн засгийн хөгжил, хувийн салбарын зохицуулалт, төрийн захиргаа хариуцсан агентлагууд
 - Хууль тогтоох эрх мэдлийн
 - Төсвийн болон байгалийн баялагтай холбоотой хороодууд
 - Орон нутгийн засаг захиргаад
 - Хяналт шалгалтын эрх бүхий дээд байгууллагууд
- Хувийн салбар
 - Тухайн оронд үйл ажиллагаа явуулж буй компаниуд
 - Дотоодын улсын үйлдвэрүүд
 - Олон улсын төрийн өмчит үйлдвэрийн газрууд
 - Дотоодын хувийн компаниуд
 - Олон улсын хувийн компаниуд
 - Хөрөнгө оруулагчид
 - Бизнес холбоод
- Иргэний нийгэм
 - Олон нийтэд тулгуурласан байгууллагууд
 - Үндэсний ТББ-ууд
 - Олон улсын ТББ болон тэдгээрийн харьяа байгууллагууд
 - Хэвлэл мэдээлэл, үйлдвэрчний холбоод, их дээд сургууль, судалгааны болон буяны байгууллагууд
- ОСИТБС-ыг хэрэгжүүлэгчид
 - Захиргаад, аудиторууд, нээлттэй болгох агентлагууд
- Олон улсын түншүүд
 - Олон улсын байгууллагууд (ОУВС, Дэлхийн Банк, НҮБ)
 - Хандивлагчид

ОСИТБС-ын зарчим ба шалгуурууд

2003 онд Их Британийн засгийн газраас санаачлан Лондон хотноо зохион байгуулсан Ланкастерын Бага Хуралд дэлхийн янз бүрийн улс орнууд, компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд оролцсон. Тус хурлаас олборлох салбар дахь төлбөр тооцоо, орлогын ил тод байдлыг дээшлүүлэх тухай Зарчмуудын Мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн. Эдгээрийг ОСИТБС-ын зарчмууд хэмээн нэрлэх болсон бөгөөд энэхүү санаачилгын тулгын чулуу болж байгаа юм.

Ланкастерын бага хурлын дараа ОСИТБС нь олон улсын түвшинд өөрсдийн удирдлага, ТББ болон олон улсын байгууллагуудаараа дамжуулан 7 триллион орчим долларын хөрөнгийг барьж байгаа улс орнууд, засгийн газрууд, үндэстэн дамнасан томоохон компаниуд болон хөрөнгө оруулагчдын институцүүдийн дэмжлэгийг авч чадсан.

Түүгээр ч барахгүй, Азербайджан, Конго, Киргиз, Сан Томе Принсипе, Зүүн Тимор, Тринидад Тобаго зэрэг улс уг зарчмуудыг өөрсдийн хэлэнд хөрвүүлэн хэрэгжүүлж эхэлсэн нь ОСИТБС-ыг арга барилаа олж хөгжихөд нь чухал хувь нэмэр болж байна. Энэ бол ОСИТБС-ын хувьд чухал ач холбогдол бүхий туршилтын үе шат байлаа. Зарчмуудын дагуу ажиллаж эхэлснээр хэрэгжүүлэгч орнууд тэдгээрийг үндэсний хэмжээний бусад санал санаачилгуудтай уялдуулан хэрэгжүүлэх болсон бөгөөд ажлын төлөвлөгөө боловсруулан өөрийн гэсэн үйл явцтай болоход чиглэсэн журам гаргаж мөрдөх болсон байна.

Энэ шатанд ОСИТБС-ыг хэрэгжүүлэхэд олж авсан арвин туршлага өөрөө уг санаачилгыг баяжуулж өгсөн. Ингэснээр түүний хэрэгжилтийн талаар тодорхой заавар зөвлөмж гаргах хэрэгцээ шаардлагын тухай өргөн хүрээтэй яриа мэтгэлцээн үүсч байгаа бөгөөд энэ явцад уг санаачилгын сайн дурын шинж чанар, тухайн улс орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх явдлыг хүндэтгэн үзэж байна.

Туршилтын шатны дараагийн үед шилжих, ОСИТБС-ыг нөөц баялаг ихтэй бусад орнуудыг оролцуулах замаар өргөжүүлэхэд уг санаачилгыг хэрэгжүүлэх хүсэлтэй бүх оронд зориулсан, харилцан хүлээн зөвшөөрсөн багц шалгуурыг бий болгох шаардлага тулгарч байна.

2005 онд Лондонд болсон ОСИТБС-ын хурлаар тэрхүү шалгууруудыг батласан төдийгүй эдгээр наад захын шаардлагуудаас аль болохоор давж ажиллахыг улс орнуудад уриалсан юм. Түүнчлэн тэд туршилтын шатанд олж авсан сургамжуудыг авч үзэхийн чухлыг онцлоод энэ нь хэрэгжүүлэгч орнууд болон дэмжигч компаниудад тустай болно гэдгийг тэмдэглэсэн. Оролцогчид

ОУВС-аас гаргасан Төсвийн Ил Тод Байдлын Тэргүүн Туршлагын Код болон Төсвийн Ил Тод Байдлын Гарын Авлагад өгүүлсэн тэргүүн туршлагын зааврыг тааламжтайгаар хүлээн авсан. Эцэст нь, оролцогчид ОСИТБС-ын Сурвалж бичгийг уг санаачилгын хэрэгжилтэнд тодорхой тайлбар бүхий заавар зөвлөгөө өгсөн нэмэлт баримт бичиг хэмээн талархан хүлээн авсан.

ОСИТБС-ын зарчмууд

1. Бид, байгалийн нөөц баялагийг ухаалгаар ашиглах нь эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг чухал хөшүүрэг болж тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад чухал хувь нэмэр оруулдаг бөгөөд хэрэв үүнийг зохистой удирдахгүй бол нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсгэж болно гэдэг итгэл үнэмшилтэй санал нэг байна.
2. Бид, аливаа улс орон байгалийн нөөц баялагаа ард иргэдийнхээ тусын тулд ашиглах асуудал нь үндэсний хөгжлийнхөө ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн тусгаар улсын засгийн газрын анхаарлын төвд байдаг гэдгийг баталж байна.
3. Бид, нөөц баялагийг олборлосны ашиг тус нь олон жилийн турш хуримтлагдах орлогоор илэрхийлэгдэх бөгөөд энэ нь зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай байхыг хүлээн зөвшөөрч байна.
4. Бид, засгийн газрын орлого, зарцуулалтын талаар ард иргэд ямар нэг ойлголттой байх нь цаашдаа тогтвортой хөгжлийн зохистой бодит хувилбаруудын сонголтын талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, мэдээлэл өгөхөд тустай гэж ойлгож байна.
5. Бид, олборлох салбарт ажиллаж буй засгийн газар ба компаниудын ил тод байдлын ач холбогдол болон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагыг онцлон тэмдэглэж байна.
6. Бид, илүү их ил тод байдлыг бий болгох явдал нь гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжуудыг хүндэтгэн үзэх байдлаар хийгдэх ёстой гэж ойлгож байна.
7. Бид, гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах нь санхүүгийн ил тод байдалд хүргэнэ гэж үзэж байна.
8. Бид, төрийн зардал, орлогын урсгалыг зохицуулах талаар засгийн газрын бүх ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагын зарчмууд, үйл явцад итгэж байна.
9. Бид, олон нийтийн амьдрал, бизнес, засгийн газрын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагын дээд зэргийн стандартуудыг дэмжин нэвтрүүлэхийн төлөө байна.

10. Бид, төлбөр болон орлогыг ил тод болгохын тулд өргөн хүрээтэй уялдаа холбоо бүхий, хэрэгжихүйц бөгөөд хэрэгжүүлэх, ашиглахад энгийн хялбар арга барил хэрэглэх шаардлагатай гэж итгэж байна.
11. Бид, аливаа улс орон дахь төлбөр тооцоог ил тод болгоход тухайн оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа олборлох салбарын бүх компаниудыг хамруулах ёстой гэж үзэж байна.
12. Бид, бүх оролцогчид, түүний дотор засгийн газар, түүний агентлагууд, олборлох салбарын компаниуд, үйлчилгээний компаниуд, олон талт байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, ТББ-д аливаа шийдэл гаргахад тус тусын чухал хувь нэмэр оруулдаг гэж итгэж байна.

ОСИТБС-ын шалгуурууд

1. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт төлж байгаа бүх материаллаг төлбөрүүд (“төлбөрүүд”), тэдгээрээс засгийн газрын хүлээн авсан бүх материаллаг орлогуудын (“орлогууд”) талаар өргөн олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.
2. Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогуудыг итгэмжлэгдсэн, хараат бус аудитаар олон улсын аудитын стандарт хэрэглэн шалгуулдаг байх.
3. Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус захирагчаар олон улсын аудитын стандарт хэрэглэн нэгтгэн дүгнүүлж, хэрэв ямар нэг зөрүүтэй байдал илэрсэн бол энэ талаарх тухайн захирагчийн дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.
4. Энэ арга нь бүх компаниуд, түүний дотор төрийн өмчийн үйлдвэрийн газруудад хамаатай байх.
5. Дээрх үйл явцыг зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгмийн төлөөлөл идэвхтэй оролцож, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулах.
6. Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцад зориулан санхүүгийн хувьд тогтвортой ажлын төлөвлөгөө гаргах бөгөөд энэхүү ажлын төлөвлөгөөнд хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг багтаасан байх.

Бүлэг 2

Нөөц баялаг ихтэй орнуудад зориулсан заавар удирдамж


Ерөнхий тойм

Томоохон олборлох салбарууд бүхий аль ч орон өөрийн байгалийн хий, газрын тос, уул уурхайн орлогын удирдлагын ил тод байдлыг дээшлүүлэх нь зүйтэй. Цаашилбал, нөөц баялаг ихтэй орнууд ОСИТБС-ын зарчмуудыг баталгаажуулаад зогсохгүй түүнээс халин уг санаачилгыг өөрийг нь хэрэгжүүлэх шаардлагатай. ОСИТБС-ыг хэрэгжүүлэх нь энэхүү хэрэгжүүлэлт тогтвортой байхыг баталж тухайн засгийн газраас улс төрийн болоод санхүүгийн үүрэг амлалт авахыг шаарддаг. Хэрэгжилтийн эхний үеийг дэмжихийн тулд Олон улсын ОСИТБС-ын Нарийн Бичгийн Дарга Нарын Газар, олон улсын байгууллагууд, хөгжлийн агентлагуудаас техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх болно.

ОСИТБС-д оролцохоор шилэгдсэн улс орон, салбар бүр өөрийн гэсэн хэрэгжилтийн загварыг боловсруулах хэрэгтэй болдог. Энэ тал дээр туршилтын шатанд зарим нэг ерөнхий сургамжууд хуримтлагдсан байгаа.

Хэрэгжилтийн үе шатууд

Доорхи бүдүүвч зурагт үзүүлснээр ОСИТБС-ыг хэрэгжүүлэхэд эхлэл, хэрэгжүүлэлт, үнэлэлт дүгнэлт гэсэн гурван үе шат байна. Үе шат бүр орлогын ил тод байдлыг бий болгох гол хүчин зүйлстэй байдаг.



Аливаа улс орон ОСИТБС-ыг баталсны дараа гол гол оролцогчидтойгоо зөвлөлдсөний үндсэн дээр эхлэлийн шатанд орно. Энэ шатанд шийдвэр гаргах засаглалын бүтцийг бий болгох, ажлын төлөвлөгөөний төсөл бэлтгэх, чадавхийг бэхжүүлэх, хөтөлбөрүүдийг тогтвортой санхүүжүүлэх зохицуулалтууд хийх зэрэг бэлтгэл ажлууд хийгдэнэ. Дараагийн буюу хэрэгжүүлэлтийн шатанд ОСИТБС-ын гол цөмийг бүрдүүлнэ. Тухайн тайлагнасан орлогуудын мэдээллийг ил тод болгох, нийтэд түгээх, хэлэлцүүлэхэд засгийн газар, компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд бүгд чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ явцад харилцан зөвшилцөлд хүрэх нь итгэлцлийг бий болгоход үнэлж баршгүй ач холбогдолтой. Гурав дахь шат нь хэрэгжилтийн үйл явцыг үнэлж дүгнэх ажлаас бүрдэнэ. Энэ шатанд санаа зовоосон гол гол бэрхшээлтэй асуудлууд болон санаачилгын хэрэгжилтийг

сайжруулах боломжуудыг шийдвэр гаргагчдад хүргэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгадаг.

Эхлэл: Санаачилгыг боловсруулах, төлөвлөх талаар харилцан зөвшилцөлд хүрч чадсан уу?

Энэ шатанд цаашдын ахиц дэвшлийн хариуцлагын тэнцвэртэй байдлыг хангах үүрэг хариуцлага засгийн газарт ноогдоно. Засгийн газар засаглалын бүтэц болон үйл явц, шаардагдах ажилтнууд, санхүүгийн механизмуудын суурь тавигдсан эсэхийг нягталж үзнэ. Ингэж нягтлахад ихэвчлэн ямар нэг нэмэлт зардал, арга хэмжээ шаардагдах ёсгүй. Эхний үе шатнаас эхлээд засгийн газар иргэний нийгмийн байгууллагууд, олборлох салбарынханыг татан оролцуулахад бүхий л хүчин чармайлтаа тавих ёстой. ОСИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэлтэй аливаа орны тухайн үйл ажиллагааны зорилтууд, ололт амжилтууд, ирээдүйн ажлын төлөвлөгөөг гол оролцогч талууд нь хамтран хүлээн зөвшөөрсөн тохиолдолд л тухайн улс ОСИТБС-ыг эхлүүлсэн гэж үзнэ.

Хэрэгжүүлэлт: Олборлох салбарын төлбөр, орлогуудын тухай мэдээлэл итгэл хүлээхүйц, ойлгомжтой байдлаар хэвлэн нийтлэгдсэн үү?

Олборлох салбарын орлогын мэдээллийг ил болгох, түгээх, хэлэлцүүлэх байнга давтагдах үйл явц байна гэдгийг гол гол оролцогч нарынхаа бүрэн оролцоотойгоор харуулж чадваас сая тухайн орон ОСИТБС-ыг хэрэгжүүлж байна гэж үзнэ. Тухайн орны хэрэгжүүлэлтийн загвар нь тус улсын соёл, хууль эрх зүйн хүрээг тусгасан байх боловч, хэрэгжүүлэгч бүх улс үүнийг ОСИТБС-ын зарчмууд ба шалгууруудын дагуу хийж гүйцэтгэх хэрэгтэй болно.

Хяналт: Хэрэгжилтийн явцын талаар жил бүр оролцогчдын санал бодлыг авах зохицуулалт байна уу?

ОСИТБС-ын хэрэгжилт нь олж авсан туршлага дээрээ дөрөөлөн жилээс жилд сайжирч байх шаардлагатай. Засгийн газрын зүгээс хэрэгжилтийн талаархи санал, зөвлөмжийг ирээдүйн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл, бүтцээр хангаж өгөх ёстой. Иргэний нийгмийн байгууллагууд хэрэгжилтийн үйл явцад нэмэлт хяналт тавин, засгийн газар ба олборлох салбартай нягт хамтран ажиллах хэрэгтэй. ОСИТБС-ын хэрэгжилтийн явцыг үнэлж дүгнэснээр, тухайлбал ОСИТБС-ын шийдвэр гаргах үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх, оролцогчдын төлөөллийг өөрчлөх, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг засч сайжруулж болно.

Санал болгох нэмэлт арга хэмжээнүүдийн хураангуй

Доорхи хүснэгтэд ОСИТБС-ын шалгууруудыг хэрэгжүүлж байгаа улсад зориулсан заавар удирдамжийг үзүүлсэн байна. Үүнд Нигери, Азербайджан, Гана, Киргиз зэрэг улсад уг шалгууруудыг хэрэгжүүлэх явцад олж авсан сургамжийг өгүүлсэн болно.

Санал болгож буй арга хэмжээнүүдийг уг санаачилгыг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал гэж үзэн тод хөхөөр бичсэн бөгөөд харин хэрэгжилтийг цаашид сайжруулах үүднээс авч хэрэгжүүлж болох **нэмэлт арга хэмжээнүүдийг** хөхөөр бичсэн байгаа.

Санал болгосон а\х

Нэмэлт а\х

Эхлэлийн шатанд

А. Элсэн орох

1. Засгийн газар гол оролцогчдоо олж тогтоосон уу?

A1. Засгийн газар оролцогчдын үнэлгээг албан ёсоор явуулж ОСИТБС-ыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх хүчин зүйлс, үндэслэл, үр нөлөөг тогтоосон уу?

2. Засгийн газар ОСИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа талаараа олон нийтэд тодорхой мэдэгдэл хийсэн үү?

3. Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтэд учирч болзошгүй аливаа саад тотгорыг олж тогтоохын тулд хууль эрх зүйн хүрээгээ хянаж үзсэн үү?

A3. Засгийн газар одоогийн орлогын талаархи мэдээллээ өөрийн вэбсайтад нийтэлсэн үү?

Б. Үүсгэн байгуулах

4. Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтийг удирдах хүнээ томилсон уу? Энэ томилгоог олон нийтэд зарлан мэдээлсэн үү?

5. Засгийн газар ОСИТБС-ын шийдвэр гаргах байгууллагад холбогдох яам, агентлагийн ахлах ажилтнуудаа оролцуулах үүрэг амлалт авсан уу?

6. Засгийн газар ОСИТБС-д өндөр түвшинд манлайлан оролцох хүсэл эрмэлзэлтэй байна уу?

7. Засгийн газар ОСИТБС-ын шийдвэр гаргахад зориулж засаглалын тодорхой бүтэц бий болгосон уу?

8. Засгийн газар ОСИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө баталсан уу?

9. Албан ёсны хороодын гишүүнчлэл нь оролцогчдын ашиг сонирхлын тэнцвэртэй байдлыг тусгаж чадаж байна уу?

9а. Засгийн газар өргөн хүрээтэй оролцогчдыг хамруулахад чиглэсэн олон нийттэй харилцах механизм бий болгож чадсан уу?

10. Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтийг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэр олж тогтоож чадсан уу?

11. Засгийн газрын зүгээс иргэд, засгийн газрын агентлагууд, бусад гол болон өргөн хүрээтэй оролцогчдын ОСИТБС-ын талаархи мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хүчин чармайлт тавьсан уу?

A9. ОСИТБС-ын хороодын бүрэлдэхүүнд компаниудын болон иргэний нийгмийн өндөр түвшний төлөөлөл орсныг нотлох баримт байна уу?

A10. Засгийн газар олон улсын байгууллагуудаас зохих ёсны суурь дэмжлэг авч чадсан уу?

В. Үйл явцын өрнөлт

12. ОСИТБС-ын ихэнх гол оролцогч нар тайлангийн маягтуудыг зохиосон тухайд сэтгэл ханамжтай байна уу?

A12. Оролцогч нарт тайлангийн маягтуудыг ойлгох, бөглөхөд нь туслах зохицуулалт хийгдсэн үү?

13. Олонхи оролцогчдын итгэл хүлээсэн, хараат бус гэж үзэж болохуйц захирагч томилогдсон уу?

14. Захирагчийг чиг үүргээ гүйцэтгэхэд нь санхүүгийн эх үүсвэрээр тогтвортой хангах зохицуулалт хийгдсэн үү?

15. Гол оролцогчдын чадавхийг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлсон уу?

16. Ил тод байдлыг бий болгохын өмнө албан болон албан бус чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрөөр хангах зохицуулалт хийгдсэн үү?

Хэрэгжүүлэлт

Г. Ил тод болгох, хэвлэн нийтлэх

17. Юуг, хэн, хэрхэн олон нийтэд ил тод болгох вэ?

17а. Ашиг орлогын ямар урсгалыг нийтэд тайлагнах вэ?

A17а. Сайн дурын үндсэн дээр тайлагнаж болох ашиг орлогын өөр ямар нэг нэмэлт урсгал байна уу?

17б. Бүх компаниуд тайлагнах нөхцлийг хэрхэн хангах вэ?

17в. Засгийн газар болон компаниуд яаж тайлагнах вэ?

18. Төлбөр болон орлогын талаар мэдүүлсэн тайлангууд найдвартай, үнэн зөв үү?

18а. Төлбөр, орлогуудад аудит хийх хараат бус, итгэмжлэгдсэн байгууллага байхгүй бол тийм аудит хийх компани эсвэл компаниудыг олж тогтоосон уу?

19. Захирагч ОСИТБС-ын тайланг хэрхэн гаргах вэ?

A19а. Тайлан гаргах явцад гарч болох алдааны зөвшөөрөгдөх түвшинг тогтоосон уу?

A19б. Ихэнх оролцогчид шаардсан тохиолдолд тайлангийн тоо баримтад хараат бус аудит хийх зохицуулалт хийгдсэн үү?

20. ОСИТБС-ын тайланг хэрхэн ил тод болгох вэ?

20а. ОСИТБС-ын тайланг нэгдсэн эсвэл хэсэгчлэн задласан байдлаар хэвлэн нийтлэх ёстой юу?

Д. Олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх

21. ОСИТБС-ын үр дүн нь нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байгаа юу?

21а. Тайлангийн үр дүнг өргөн хүрээтэй тарааж танилцуулах тогтсон заавар журам бий юу?

22. Төлбөр ба орлогын тайлагнасан дүнгийн талаар гол оролцогч нарыг оролцуулан ямар нэгэн хэлэлцүүлэг хийсэн үү?

A22. Тэрхүү хэлэлцүүлэгт өргөн хүрээтэй олон оролцогчдыг хамруулсан уу?

Үнэлэлт дүгнэлт

Е. Үнэлэлт дүгнэлт

23. ОСИТБС-д хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тогтсон зохицуулалт байна уу?

A23a. Албан ёсны, хараат бус үнэлгээний механизм байна уу?

A23б. Хэрэгжилтээс олж авсан сургамжуудыг бусад улс орон, оролцогчидтой хуваалцсан уу?

24. Шийдвэр гаргах журам болон бусад ажиллагааг боловсруулахад эргэх холбоо-ны механизм нөлөөлсөн үү?

Эхлэл

А. Элсэн орох

Санал болгож буй арга хэмжээ 1: Засгийн газар гол оролцогчдоо олж тогтоосон уу?

ОСИТБС-ын зарчмын дагуу бүх оролцогч нар-засгийн газар, түүний агентлагууд, олборлох үйлдвэрүүд, үйлчилгээний компаниуд, олон улсын байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, ТББ-ууд бүгдээрээ уг санаачилгын хэрэгжилтэд оруулах тус тусын чухал хувь нэмэртэй байдаг. Тиймээс энэхүү ажлын бүр эхнээс нь гол болон өргөн хүрээтэй оролцогчдыг татан оролцуулах нь чухал байдаг. Тэднийг татан оролцуулах явдал улс орон бүрд харилцан адилгүй байж болох боловч гол нь уг санаачилгыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй оролцох шаардлагатай бүх оролцогчдыг хамруулах ёстой.

Эдгээр оролцогчдыг эртнээс тодруулж тэдэнтэй хамтран ажиллах нь уг санаачилгыг амжилттай хэрэгжүүлэхэд онцгой чухал юм. ОСИТБС-аар гаргаж байгаа аливаа улс орны идэвх зүтгэл, өөрийн болгосон байдал, итгэл хүлээх чадварын түвшин нь гол оролцогчид уг санаачилгын хэрэгжих хугацаа, ашиг тусад хэр сэтгэл ханамжтай байгаагаас ихээхэн хамаардаг.

Нэмэлт арга хэмжээ А1: Засгийн газар оролцогчдын үнэлгээг албан ёсоор явуулж ОСИТБС-ыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх хүчин зүйлс, үндэслэл, үр нөлөөг тогтоосон уу?

Зарим оронд оролцогчдын тоо харьцангуй цөөн, олж тогтооход хялбар байдаг. Хэдий тийм боловч тус салбарын хэмжээ, нарийн төвөгтэй байдлаас шалтгаалж сонирхогч талуудын тоо эрс өсөхөд хүрдэг. Ийм тохиолдолд, эдгээр талууд, ОСИТБС-ын хэрэгжилтийн тэргүүлэх хүчний талаар бүрэн дүүрэн, албан ёсны задлан шинжилгээ хийх нь аливаа орон ОСИТБС-ыг хэрхэн яаж хэрэгжүүлэх тухай шийдвэр гаргахад тустай байна.

Санал болгож буй арга хэмжээ А2: Засгийн газар ОСИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа талаараа олон нийтэд тодорхой мэдэгдэл хийсэн үү?

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эхлэхийн тулд засгийн газар ОСИТБС-ын зарчмуудыг хүлээн зөвшөөрч тус санаачилгыг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа талаараа олон нийтэд хандсан тодорхой мэдэгдлийг орон нутгийн болон үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх хэрэгтэй. Ийнхүү мэдэгдэл хийх нь ОСИТБС-ыг батлахаас илүү чухал ач холбогдолтой бөгөөд ОСИТБС-ын шалгууруудыг хангахын тулд тодорхой (тогтсон)

Жишээ 1.

Нигери улсад Үндэсний Оролцогчдын Ажлын Хэсгийн 28 гишүүн тогтоогдсон гол оролцогчдыг төлөөлдөг. Эдгээр оролцогчид нь иргэний нийгэм (2), хэвлэл мэдээлэл (1), үндэсний ассамблей (2), төрийн ассамблейд (2), олон улсын газрын тосны компаниуд (3), зохион байгуулалттай хувийн салбар (4), Холбооны засгийн газар (14) зэрэг болно.

хугацаанд засгийн газраас авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээнүүдийг зааж өгөх ёстой. Энэхүү мэдэгдлийг төрийн тэргүүн эсвэл засгийн газрын эрх бүхий төлөөлөгч хийх нь зүйтэй.

Засгийн газрын хувьд үндэсний ОСИТБС-ын вэбсайт бий болгох хэрэгтэй ба хийсэн мэдэгдлээ тэрхүү сайтдаа байрлуулах нь зүйтэй. Мэдэгдлийн нэг хувийг олон улсын ОСИТБС-ын Нарийн Бичгийн Дарга нарын газарт хүргүүлж тэдний вэбсайтад мөн тавиулах юм.

Жишээ 2

Киргиз улсын хувьд улсын компаниудад хараат бус, аудит хийхийг зөвшөөрсөн тусгай хууль журам хэрэгтэй.

Азербайжанд хууль эрх зүйн өөрчлөлтүүд шаардлагагүй боловч янз бүрийн оролцогч нарын хооронд байгуулсан Ойлоголцлын Санамж Бичиг нь эрх зүйн баримт бичгийн үүрэг гүйцэтгэж болдог.

Жишээ 3

Нигерид ОСИТБС-ын хуулийн төсөл нь санхүүгийн хариуцлага ба мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд нэмэлт болон орж байна.

Санал болгож буй арга хэмжээ 3: Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтэд учирч болзошгүй аливаа саад тотгорыг олж тогтоохын тулд хууль эрх зүйн хүрээгээ хянаж үзсэн үү?

ОСИТБС нь төсвийн хяналтын механизмуудаас гадна үйл ажиллагаа нь тогтворжсон орлогын удирдлагын эрх зүйн хүрээнд сайтар зохицсон байх ёстой. Иймээс ОСИТБС нь засгийн газарт шаардлага тавих ёсгүй юм. Хэдий тийм боловч зарим тохиолдолд ОСИТБС-ыг хуульчилж өгөх, тухайлбал ил тод байдал, орлогын болон салбарын бодлого, хууль тогтоомжийг шинээр бий болгох, эсвэл одоо үйлчилж байгаа ОСИТБС-тай холбоотой бодлого, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарч болдог. Хэрэв хууль эрх зүйн нэмэлт арга хэмжээ шаардлагатай бол засгийн газар эхлээд одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийнхоо тодорхой, нийцтэй байдлыг тодотгох үүднээс үнэлж дүгнэх хэрэгтэй. Засгийн газар олборлох үйлдвэрүүдийн орлогын удирдлага дахь ил тод байдлын асуудал нь авилгын эсрэг хууль тогтоомжуудад тусгагдсан эсвэл хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг хамарсан хууль тогтоомжоор баталгаажсан эсэх, эсвэл олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудыг гаргаж тавьсан төрийн албан тушаалтнуудыг хамгаалсан эрх зүйн актуудад тусгалаа олсон эсэхийг авч үзэж болох юм.

Нэмэлт арга хэмжээ А3: Засгийн газар одоогийн орлогын талаархи мэдээллээ өөрийн вэбсайтад нийтэлсэн үү?

Хэдий бүрэн бус ч, байгаа орлогуудын, тухайлбал олборлох салбараас орж буй орлогын мэдээллийг нийтлэх нь тоон мэдээллийн чанарыг сайжруулах талаар үнэлэлт дүгнэлт өгөх бааз суурь болдог. Эдгээр мэдээллийг засгийн газар өөрийн вэбсайтандаа бусад үндэсний хэмжээний ОСИТБС-ын вэбсайтуудтай холбох холбоосуудын хамт тавьж өгөх нь зүйтэй. Олборлох үйлдвэрүүдийн орлогыг эртнээс иймэрхүү маягаар тайлагнах нь засгийн газар ил тод байдлын төлөө байгаагийн хөдөлшгүй нотолгоо болох юм.

Б. Үүсгэн байгуулах

Санал болгож буй арга хэмжээ 4: Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтийг удирдах хүнээ томилсон уу? Энэ томилгоог олон нийтэд зарлан мэдээлсэн үү?

Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хангалттай өндөр түвшний бүх оролцогчид нь итгэж болох тийм хүнийг томилох ёстой. ОСИТБС-ыг хэрэгжүүлэх нь өөрөө хэд хэдэн яам, агентлагын хоорондын хамтын ажиллагааг шаарддаг учраас тэрхүү томилогдсон хүн нь энэхүү хамтын үйл явцыг удирдах эрхтэй байх шаардлагатай.

Өнөөг хүртэл хуримтлагдсан туршлагаас харахад эдгээр хүмүүс холбогдох аль нэг яам, агентлагт байрлаж байгаа. Томилогдсон хүнийг орлогч, туслах ажилтнаар хангах шаардлагатай байж болох ч тусгай нэгж байгуулаад байх шаардлагагүй байж болно. Бүх тохиолдолд, тэрхүү ажилтныг зохицуулах үүрэг болон улс төрийн аливаа нөлөөллөөс ангид үүргээ гүйцэтгэх эрх чөлөөгөөр нь хангаж өгсөн байх хэрэгтэй. Хэрэв үндэсний ОСИТБС-ын вэбсайт бий болгосон бол тэрхүү томилогдсон хүний нэр, холбоо барих хаяг зэргийг вэбсайтад байрлуулах хэрэгтэй ба энэ нь тухайн хувь хүн болон засгийн газрын хариуцлагыг өргөн хүрээтэй, ил тод болгосон хэрэг болох юм.

Санал болгож буй арга хэмжээ 5: Засгийн газар ОСИТБС-ын шийдвэр гаргах байгууллагад холбогдох яам, агентлагийн ахлах ажилтнуудаа оролцуулах үүрэг амлалт авсан уу?

Засгийн газрын ахлах ажилтнууд цаг зав багатай гэдгийг энд хүлээн зөвшөөрч байна. Хэдий тийм боловч ОСИТБС нь засгийн газрын олон тооны яам, агентлагийг төв, орон нутгийн хэмжээнд хамтран ажиллахыг шаарддаг. Тийм учраас засгийн газар зохих ёсны холбогдох ахлах ажилтнуудаас бүрдсэн албан ёсны хороодод төлөөллөө оролцуулах нь чухал юм.

Санал болгож буй арга хэмжээ 6: Засгийн газар ОСИТБС-д өндөр түвшинд манлайлан оролцох хүсэл эрмэлзэлтэй байна уу?

Өндөр түвшний улс төрийн манлайллаар тогтвортой хангах нь ОСИТБС-ын үйл явцыг урагшлуулах, хэрэгжилтийн явцад гарах асуудлыг шийдвэрлэхэд тустай байх нь олонтаа.

Жишээ 4

Гана улсад ОСИТБС-ын нарийн бичгийн дарга нарын газарт зориулж олон нийтэд хүртээмжтэй нарийн зохион байгуулалт бий болгосон. Энэ нь Уул Уурхайн Яаман дээр байгуулагдсан тусгай нэгж бөгөөд төв зохицуулалтын үүрэгтэй

Жишээ 5

Киргиз улсад ОСИТБС-ын хорооны гишүүнд Ерөнхий сайдын ахлах зөвлөхүүд болон Үйлдвэр Худалдааны Яам, Гадаад Хэргийн Яам, Хууль Зүйн Яамны өндөр албан тушаалтнууд багтдаг.

Жишээ 6

Киргиз улсад Ерөнхий сайд нь ОСИТБС-ын Зөвлөлдөх Хороог даргалдаг бөгөөд Сангийн дэд сайд нь ОСИТБС-ыг хэрэгжүүлэх хороог тус тус тэргүүлж уг санаачилгыг бүхэлд нь удирддаг.

Жишээ 7

Гана улсын 17 хүний бүрэлдэхүүнтэй Хэрэгжүүлэх Хорооны 12 нь засгийн газрын төлөөлөгчид, 1 нь компаниудыг төлөөлсөн үйлдвэрлэлийн холбоодын төлөөлөл, бусад нь хандивлагчид, иргэний нийгмийн төлөөлөл байдаг. Хэрэгжүүлэх Хороо нь ОСИТБС-ын янз бүрийн хэтийн төлвийн талаар дугуй ширээний ярилцлага зохион байгуулж санал шүүмжлэл гаргадаг.

Жишээ 8

Азербайжанд оролцогч талууд Ойлголцлын Санамж Бичигт гарын үсэг зурсан бөгөөд үүндээ өөрсдийн эрх үүргээ тодорхойлсон. Санамж бичгийг Үндэсний ОСИТБС-ын вэб сайтын http://www.oilfund.az/doc/memorandum_en.doc хаягт байрлуулсан байна.

Санал болгож буй арга хэмжээ 7: Засгийн газар ОСИТБС-ын шийдвэр гаргахад зориулж засаглалын тодорхой бүтэц бий болгосон уу?

ОСИТБС нь янз бүрийн оролцогч талууд, байгууллагууд, салбарын төлөөлөгчид болон түншүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрээ гаргах ёстой байдаг санаачилга юм. ОСИТБС-ын хэрэгжилтэнд зориулж ямар ч засаглалын бүтэц сонгосон байлаа гэсэн засгийн газар өөрийн зүгээс шийдвэр гаргах үүрэг хариуцлагаа сайтар тодорхойлсон эсэх, зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл ажиллагаа хоорондоо сайтар уялдсан эсэхийг нягтлан үзэх ёстой.

Санал болгож буй арга хэмжээ 8: Засгийн газар ОСИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө баталсан уу?

ОСИТБС-ыг хэрэгжүүлэхийн төлөө байгаагаа харуулахын тулд Засгийн газар ОСИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө гол гол оролцогч талуудтай хамтран хэлэлцэж, тэр тухай мэдээллээ олон нийтийн хүртээл болгох нь чухал. Уг ажлын төлөвлөгөөнд засгийн газар, салбар, дотоодын ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх асуудал, төлбөр болон орлогыг нэгтгэн гаргахад туслах алхамууд, оролцогч бүр тогтоосон зардал, хугацаанд багтаж тавьсан зорилтдоо хүрсэн эсэхийг хэмжих хэмжилт зэргийг оруулна.

Энэхүү ажлын төлөвлөгөөг ОСИТБС-ын үндэсний вэб сайтуудад байрлуулах, улмаар бүх оролцогч талуудыг төлөвлөгөөт арга хэмжээ, журмуудыг, ялангуяа, чадавхийг бэхжүүлэх, үр дүнг тайлагнах, олон нийтэд танилцуулахтай холбоотой хэсгийг урьдчилан мэдэх боломжтой болгох нь зүйтэй.

Санал болгож буй арга хэмжээ 9: Албан ёсны хороодын гишүүнчлэл нь оролцогчдын ашиг сонирхолын тэнцвэртэй байдлыг тусгаж чадаж байна уу?

Оролцогч талуудын тоо олон байх талтай, харин зохицуулах хорооны гишүүдийн тоо хязгаартай байвал зохих учраас тэдгээрийн ялгавартай байдал, хамралт, төлөөлөл зэргийг тусган гишүүнчлэлийн талаар бодитой шийдвэр гаргах шаардлагатай.

Нэмэлт арга хэмжээ А9: ОСИТБС-ын хороодын бүрэлдэхүүнд компаниудын болон иргэний нийгмийн өндөр түвшний төлөөлөл орсныг нотлох баримт байна уу?

ОСИТБС-ын хороод дахь иргэний нийгэм болон компаниудын төлөөллийн түвшин орон бүрт харилцан адилгүй байдаг бөгөөд энэ нь янз бүрийн оролцогчдын идэвх оролцооны түвшин, хэрэгжилтээс хүлээгдэж буй үр дүн өөр өөр байдгаас үүдэлтэй. Хэдий тийм боловч ер нь тус хороодод иргэний нийгэм болон хувийн салбарын өндөр түвшний төлөөлөл байх нь тэдгээрийн ажлын үр нөлөөг дээшлүүлдэг гэж үздэг.

Зохих түвшний төлөөлөл байхын хажуугаар гишүүнчлэл тууштай байх нь ач тустай. Тэгэх боломжгүй үед шинээр орох төлөөлөгчдийг бүрэн шүүж оруулах үүрэг хариуцлагыг холбогдох байгууллагууд хүлээдэг.

Санал болгож буй арга хэмжээ 9а: Засгийн газар өргөн хүрээтэй оролцогчдыг хамруулахад чиглэсэн олон нийттэй харилцах механизм бий болгож чадсан уу?

Засгийн газрын зохицуулалт нь хэрэгжилтийн эхний шатанд элсүүлсэн бүх оролцогч талуудыг ОСИТБС-ын хөгжлийн явцад ашиг сонирхлоо илэрхийлэх сувагтай байх боломжоор хангаж өгөх шаардлагатай. Тухайлбал олон нийттэй харьцахдаа жижиг компани, иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулаад зогсохгүй нийслэл хотоос хальж орон нутгийн байгууллагуудыг хамруулах байдлаар өргөжүүлэх нь чухал.

Дээр өгүүлсэнчлэн Засгийн газар ОСИТБС-ын үндэсний вэб сайт ажиллуулах нь зүйтэй. ОСИТБС-ын үйл явц, засаглал, олон нийтийг хамруулах ажлын зохион байгуулалт гээд бүхий л мэдээллийг тус вэб сайтад тавьж болох юм.

Санал болгож буй арга хэмжээ 10: Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтийг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэр олж тогтоож чадсан уу?

Хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд засгийн газар дотоодын санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг аль болох хурдан олох хэрэгтэй. Засгийн газрын хувьд нэг арга зам нь төлөвлөгөөнд тодорхойлсон эхлэлийн шатны дараа буюу тухайлбал, эхний 3 тайлант үеийн дараагаас эхлэн газрын тос болон бусад ашигт малтмалаас орох орлогоос ОСИТБС-ын зардлыг санхүүжүүлж болох юм.

Жишээ 9

Нигери улсын хувьд оролцогч талуудын ажлын хэсэгт өргөн хүрээтэй төлөөлөл бий болгохыг эрмэлзсэн бөгөөд тиймээс гишүүнчлэлдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эвлэл холбоод болон хуульчдыг анхнаас нь оруулсан. Гишүүд нь өөрсдийн төлөөлж байгаа хэсгийн итгэл найдварыг хүлээж, итгэмжлэгдсэн болохоо харуулах үүрэгтэй гэж үздэг.

Жишээ 10

Гана улсын Хэрэгжүүлэх Хороонд жижиг компаниудын төлөөллийг оролцуулах хэрэгтэй гэж зарим оролцогчид үздэг. Энэ бүлгийн сонирхолыг харгалзая гэвэл тэдгээрийн төлөөллийг үйлдвэрлэлийн холбоодоор дамжуулан оролцуулж болох юм.

Жишээ 11

Нигери улсад ОСИТБС-ын хэрэгжилтийг дэмжих төсвийн зүйл ангийг ОСИТБС-ын хуулийн төсөлд дэвшүүлжээ. Киргиз улсад төрийн өмчийн уул уурхайн компанийн ОСИТБС-ын аудитын төлбөрийг санхүүжүүлэх зорилгоор уурхай дахь засгийн газрын хувьцааг зарсан орлогын багахан хэсгийг ашиглаж байна. Харин Азербайжанд уг зардлыг засгийн газар болон корпорациуд ээлжлэн даадаг.

Жишээ 12

Ганад ОУХС-аас ОСИТБС-ыг танилцуулах бага хурлыг санхүүжүүлсэн. Энэ хурлаар:

- ОСИТБС-ын чиг хандлага, тус улсад эзлэх байр суурийг тодорхойлсон.
- ОСИТБС-ыг туршилтын журмаар хэрэгжүүлж буй бусад орны байдлын талаар мэдээлэл солилцсон.
- Өөрийн орон дахь ОСИТБС-ын хэрэгжилтийн үндсийг тавьсан.
- ОСИТБС-ын үйл явцад тулгарч болох боломжууд болон бэрхшээлүүдийг тодорхойлсон.

Жишээ 13

Нигерид явуулсан оролцогчдын сонирхлыг тандсан судалгаагаар хариулагчдын (газрын тосны ажилчид, бизнес эрхлэгчид болон багш нар) “Баррель газрын тосноос та нар юу хүртдэг вэ?” гэсэн асуултанд өгсөн ерөнхий хариулт нь: хэрэв 1 баррель тосыг 30 ам.доллар гэвэл 5 нь үйлдвэрлэлийн зардалд, 5 нь засгийн газрын татварт, үлдсэн 20 ам.доллар нь компанид очдог гэсэн байв.

Нэмэлт арга хэмжээ А10: Засгийн газар олон улсын байгууллагуудаас зохих ёсны суурь дэмжлэг авч чадсан уу?

ОСИТБС-ыг хөгжүүлэх эхний шатандаа яваа улс орнуудад олон улсын байгууллагууд түүнчлэн зарим улсууд санхүүгийн болон техникийн зохих тусламж, дипломат дэмжлэг үзүүлэхээ амлаад байна. Энэхүү гадаад дэмжлэг нь ОСИТБС-ын түншүүдийн хооронд уулзалтууд зохион байгуулахад туслах эсвэл хэрэгжилтийг дэмжих техникийн зөвлөхүүдээр хангах зэрэг агуулгатай байдаг. Эдгээр дэмжлэг нь хэрэгжүүлэх засгийн газар уг үйл явцыг өөрийн болгоход саад бэрхшээл учруулах ёсгүй бөгөөд эхний шатны дараа энэ дэмжлэг хэр тогтвортой үргэлжлэх вэ гэдэг асуудлыг авч үзэх шаардлагатай.

Санал болгож буй арга хэмжээ 11: Засгийн газрын зүгээс иргэд, засгийн газрын агентлагууд, бусад гол болон өргөн хүрээтэй оролцогчдын ОСИТБС-ын талаархи мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хүчин чармайлт тавьсан уу?

ОСИТБС нь засгийн газрын өөрөө хэрэгжүүлэх ажил учраас ОСИТБС-ын талаарх ойлголтыг эхний ээлжинд газрын тосны буюу уул уурхайн яамд, сангийн яам, төрийн аудитын байгууллага зэрэг засгийн газрын холбогдох байгууллагуудын хүрээнд өгөх нь чухал. Засгийн газрын холбогдох байгууллагууд, ЯБСББ болон түүнийг боловсруулах яриа хэлэлцээ, зөвлөгөөнүүд дээр байгалийн баялагийн орлогын асуудлууд хангалттай туссан эсэхийг нягтлан үзэх хэрэгтэй. Мөн түүнчлэн засгийн газар гол оролцогчдын чадавхийг бэхжүүлэх тогтвортой хөтөлбөр санаачилж эхлүүлэх ёстой. Олборлох үйлдвэрүүдийн орлогыг тойрсон асуудлуудын тухай мэдлэг олон оронд хангалтгүй буюу буруу ойлголт агуулсан хэмжээнд байдаг (жишээ 13-ыг үз).

Өнөөдөр ОСИТБС-ыг хэрэгжүүлж буй орнуудын засгийн газар оролцогч талуудын өргөн хүрээг хамарсан чадавхийг бэхжүүлэх янз бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүний жишээнд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ОСИТБС-ыг үүсгэн байгуулахад оролцуулах, холбогдох яамдад зориулсан олон нийтийн харилцааны стратегийг боловсруулах, байгалийн баялагийн орлого болон засгийн газрын хариуцлагатай байдлын ач холбогдлын тухай ойлголтыг улсын сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах зэрэг болно.

В. Үйл явцын өрнөлт

Санал болгож буй арга хэмжээ 12: ОСИТБС-ын ихэнх гол оролцогч нар тайлангийн маягтуудыг зохиосон тухайд сэтгэл ханамжтай байна уу?

Тайлангийн маягтуудын загварыг (тэдгээрийн зарим жишээг энэхүү сурвалж бичгийн хавсралтад оруулав) ОСИТБС-ын орлогыг ил тод болгох зорилгоор боловсруулаад байна. ОСИТБС-ыг хэрэгжүүлэх явцад улс орнууд эдгээр маягыг өөрийн орны болон салбарын өвөрмөц онцлог шаардлагуудыг тусгах үүднээс засч өөрчлөн өргөжүүлж болно.

Зарим оронд эдгээр маягтад өөрчлөлт оруулах ажлыг хариуцан зохицуулах хувь хүн буюу байгууллага ажиллуулж болдог. Ийм тохиолдолд тэдгээр нь техникийн хувьд чадвартай байхаас гадна гол оролцогч талуудын итгэлийг хүлээсэн, тэдэнд ойр дөт байх нь чухал.

Нэмэлт арга хэмжээ А12: Оролцогч нарт тайлангийн маягтуудыг ойлгох, бөглөхөд туслах зохицуулалтууд хийгдсэн үү?

Тайлангийн маягтуудын хамрах хүрээг хэлэлцэх, эргэж хянах ажил нь заримдаа газрын тосны болон уул уурхайн орлогын янз бүрийн орлогын урсгалыг хөрвүүлэн ойлгох техник чадвар дутагдсанаас болон хэр зэрэг сайн нягтлан бодох бүртгэл хийгдсэнээс хамаарч хязгаарлагддаг.

Санал болгож буй арга хэмжээ 13: Олонхи оролцогчдын итгэл хүлээсэн, хараат бус гэж үзэж болохуйц захирагч томилогдсон уу?

Компаниуд болон засгийн газраас гаргасан орлогын тоон мэдээллийг цуглуулах, үнэлэх ажлыг хариуцсан захирагч томилох шаардлагатай болдог. Нөгөөтэйгүүр тэрхүү захирагчийн хараат бус, чадварлаг байдалд итгэх оролцогчдын итгэл онцгой чухал. Энэхүү захирагч хувийн аудитын компани, хувь хүн эсвэл одоо ажиллаж байгаа эсвэл тусгайлан шинээр байгуулагдсан албан ёсны байгууллагын аль нь ч байж болох ба гол нь засгийн газраас хараат бус, түүний нөлөөллөөс ангид гэж бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн этгээд байна.

Сонирхолын зөрчил эсвэл сонирхолын зөрчлийн тухай ойлголт бол авч үзвэл зохих асуудлын нэг юм. Жишээлбэл, хэрэв томилогдсон захирагч нь

Жишээ 14

Азербайджанд тендер зарлан явуулж, төлбөр ба орлогын тоо баримтыг хянах үүрэгтэй хараат бус захирагчийг томилох (одоо энэхүү үүргийг нэгэн аудитын компани гүйцэтгэж байгаа) зорилгоор засгийн газар, компани, ТББ-ын төлөөллөөс бүрдсэн түр хороо байгуулсан.

тайлагнагч компаниудын нэгэнд аудит хийж байгаа аудитын компани байвал үүнийг орлогын гүйлгээ хариуцсан хэн нэг засгийн газрын ажилтантай холбоотой байж болзошгүй гэдэг үүднээс сонирхолын зөрчилд тооцож болох юм.

Санал болгож буй арга хэмжээ 14: Захирагчийг чиг үүргээ гүйцэтгэхэд нь санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангах зохицуулалт хийгдсэн үү?

Оролцогч нар аль хэр нарийвчилсан мэдээлэл шаардахаас хамааран засгийн газрын холбогдох агентлагууд болон олборлох үйлдвэрлэлийн компаниудаас орлогын тоо баримт цуглуулан аудит хийх нь нэлээд нарийн төвөгтэй ажил байдаг. Энэ нь цаанаа зардал дагуулах бөгөөд хэдийгээр эхний санхүүжилт нь гадаад эх үүсвэрээс ирж байгаа ч гэсэн ер нь засгийн газар анхнаасаа өөрийн гэсэн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг олж авсан байх нь чухал.

Санал болгож буй арга хэмжээ 15: Гол оролцогчдын чадавхийг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлсон уу?

ОСИТБС-ын дагуу тайлан гаргахдаа хялбар, ойлгомжтой байдлаар хийж, цаашид уг тайланг хэрэглэгчдэд шаардагдах чадавхийг бэхжүүлэх ажлын хэмжээг багасгах хэрэгтэй. Гэхдээ ОСИТБС-ын үйл явцад итгэх итгэлийг бий болгох үүднээс гол оролцогч талууд тайлагнахтай холбоотой үйл явцын талаар ямар нэг ойлголтой байх шаардлагатай болно.

Чадавхийг бэхжүүлэх гэдгийг зөвхөн хяналт шинжилгээ эсвэл аудит хийх чадвар талаас нь харж болохгүй. Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, зарим тохиолдолд салбарын оролцогчид салбарын үйлдвэрлэлийн ажил гүйлгээнээс юу олж мэдэж авбал зохих, санаа бодлоо засгийн газар болон салбарын оролцогчдод хэрхэн хүргэх тал дээр шийдвэр гаргах, холбоо хэлхээ тогтоох, зохион байгуулалтын болон техник чадавхиа бэхжүүлэх шаардлагатай байгаагаа илэрхийлдэг.

Санал болгож буй арга хэмжээ 16: Ил тод байдлыг бий болгохын өмнө албан болон албан бус чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрүүдээр хангах зохицуулалтууд хийгдсэн үү?

Олж тодорхойлсон чадавхийн хэрэгцээг авч үзэх нь цаг нэлээд авах ажил тул аль болох хурдан эхлэх хэрэгтэй. Хэрэгжүүлж эхлэхийн өмнө ОСИТБС-

Жишээ 15

Одоогийн байдлаар Нигери улсад чадавхи бэхжүүлэх дараахь хэрэгцээ шаардлагуудыг тогтоогоод байна:

- Иргэний нийгмийн байгууллагууд одоогийн үүргээ илүү үр дүнтэй биелүүлэхэд нь зориулж техник чадавхийг нь бэхжүүлэх
- Тайлангийн маягт бөглөхөд зориулж тайлагнагч аж ахуйн нэгжүүдийн техник чадавхийг бэхжүүлэх;
- Засгийн газрын гүйцэтгэх ажлын тогтолцоонд зориулж зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх;
- Засгийн газраас илүү уялдаа холбоотой хүчин чармайлт гаргах үүднээс хэлхээ холбоо тогтоох чадавхийг нь бэхжүүлэх;
- Газрын тос, уул уурхайн үйлдвэрлэлийн орлого, төсвийн удирдлагын үндсэн асуудлууд, үүрэг хариуцлагыг ойлгох техник чадавхийг бэхжүүлэх;
- ТББ болон корпорацуудын шийдвэр гаргах, зөвшилцөлд хүрэх чадавхийг дээшлүүлэх.

ын талаархи ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх тодорхой чиглэлүүдээр зохих хөтөлбөрүүдийг эхлүүлсэн байх хэрэгтэй.

Ингэх нь уг санаачилгыг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаагаа харуулахыг хүссэн орнуудад оноо авах боломж олгох бөгөөд хэрэгжилтийн үйл явцыг анхнаас нь эрчимжүүлнэ. Эдгээр хөтөлбөрүүдэд зориулсан санхүүжилтийн тогтвортой эх **үүсвэр олж хангах нь санаачилгын цаашдын хэрэгжилтэд чухал ач холбогдолтой байх болно.**

Жишээ 16

Одоогийн байдлаар Нигери улсын иргэний нийгэмд ОСИТБС-ын хэрэгжилтийг дэмжих чадавхийг бэхжүүлэхэд зориулсан санхүүжилтийн 90%-ийг олон улсын хандивлагчид олгож байна. Гэвч иргэний нийгмийн байгууллагууд нь орлогын тогтвортой эх үүсвэртэй байх хэрэгцээг ойлгож байгаа бөгөөд дотоодын санхүүжилтийн кампанит ажил зохион байгуулахад туслалцаа авах хүсэлтэй байна.

Хэрэгжүүлэлт

Г. Ил тод болгох ба хэвлэн нийтлэх

Жишээ 17

Нигери улс дахь тайлангийн маягтын хамрах хүрээний асуудлууд:

- Аюулгүй байдлын зардал зэрэг техникийн бус зардлууд орсон уу?
- Зарим компаниуд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулж төлөх 3%-ийн татвараа суулгаж өгдөг тул гарал үүслийн хураамжийг аудитад хэрхэн тусгах вэ?
- Компаниудаас сургууль болон эрүүл мэндийн төв барих зардал, бусдын цалинд төлсөн мөнгө “үйлдвэрлэлийн зардал” гэж тусгагдах уу эсвэл компаний нийгмийн хөрөнгө оруулалт гэж тооцогдох уу?

Жишээ 18

Гана улсад ил тод байдлын байгууллага нь орлогын тоо баримтыг жилд хоёр удаа нийтэд мэдээлж байхаар тохиролцсон. Орлогын урсгалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, олсон орлогодоо төлөх төлбөр, сэргээн босголтын татвар болон бусад олон жижиг хураамжууд ордог. Цаашилбал, корпорацийн түншлэгч нар 2002 оноос нийгэмд оруулсан хувь нэмрээ боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг салбаруудаар задлан нийтэлж байхаар болсон.

Санал болгож буй арга хэмжээ 17: Юуг, хэн, хэрхэн олон нийтэд ил тод болгох вэ?

Эхний үе шатанд засгийн газар болон компаниудын тайлангийн загварыг боловсруулах ажиллагаа зөвшөөрөгдсөн, ОСИТБС-ын тайланг бэлтгэх захирагчийг томилсон байх ёстой. Хэрэгжилтийн эхний шатанд тайлангийн маяганд орох ил тод байдлын нарийн хүрээ, шинж чанарыг бий болгож өгсөн байх нь чухал.

Энэхүү хэлэлцүүлэгт оролцуулахын тулд бүх оролцогч талуудын чадавхийг бэхжүүлсэн байх ёстой. Үндсэн оролцогч талууд нь засгийн газар ба компаниуд байж болох боловч бүх талыг татан оролцуулахын тулд чармайх хэрэгтэй.

Тайлангийн хамрах хүрээ ямар байхыг төсвийн дэглэмд тулгуурлан тодорхойлох талтай байдаг. Энэ нь ихэнхдээ хэрэглэж болохуйц бүтээгдэхүүн хуваах гэрээ байдаг. Хэрэв оролцогчид тодорхой зүй ёсны зардлуудыг (тухайлбал аюулгүй байдлын, сургалтын, дэд бүтцийн г.м) багтаахыг хүсвэл энэ тухайд тайлагнах баримтад дэлгэрэнгүй тусгах хэрэгтэй. Ерөнхийдөө, ОСИТБС-ын тайлан нь ашиг орлогын урсгалын цаана буй зардлуудын хараат бус аудитаар шалгагдах цар хүрээг сайтар тодорхойлж өгөх ёстой юм.

Санал болгож буй арга хэмжээ 17а: Ашиг орлогын ямар урсгалыг нийтэд тайлагнах вэ?

Ашиг орлогын урсгал гэдэг нь тухайн хүлээн авагч засгийн газар олборлох үйлдвэрүүдээс авах эдийн засгийн үр өгөөжийн боломжит аливаа эх үүсвэрийг хэлж байгаа юм. Эдгээрт эдийн засгийн шууд бус үр өгөөж болох дэд бүтцийг барьж байгуулах, орон нутгийн иргэдийг ажилтай болгох зэргийг оруулна гэж тооцоогүй болно.

Бүхий л материаллаг ашиг орлогын урсгалыг тайлагнах ёстой. Орхигдуулсан буюу буруу тайлагнаснаас болж ОСИТБС-ын эцсийн тайланг гажуудуулж болзошгүй ашиг орлогын аливаа урсгалыг материаллаг гэж үзнэ.

Ашиг орлогын урсгалын дараахь тохиолдлуудад материаллаг гэж үзэхийг зөвлөмж болгожээ:

Хувилбар 1: Тайлант хугацаан дахь тухайн хүлээн авагч засгийн газрын тооцоолж байсан нийт үйлдвэрлэлийн үнэ цэнийн А%-иас илүү бол;

Хувилбар 2: Тайлант хугацаан дахь тухайн компанийн хүлээн авагч тухайн улсад үйлдвэрлэхээр тооцоолж байсан нийт үйлдвэрлэлийн үнэ цэнийн Б%-иас илүү бол; эсвэл

Хувилбар 3: В сая ам.доллараас (эсвэл Г сая дотоодын мөнгөн дүнгээс) илүү бол.

Ашиг орлогын урсгалд дараахь зүйлсийг оруулж болно:

Ашиг орлогын урсгал	Нэмэлт тодорхойлолтууд
Хүлээн авагч засгийн газрын үйлдвэрлэлийн эрх	Энэ нь нийт үйлдвэрлэлд хүлээн авагч засгийн газрын эзлэх хувь хэмжээ юм. Энэхүү үйлдвэр-лэлийн эрхийг хүлээн авагч засгийн газарт шууд эсвэл дотоодын төрийн өмчит компанид шилжүүлж болно. Энэ урсгал нь бэлэн мөнгөөр эсвэл бэлэн бус (мөнгөн бус) байдлаар хийгдэж болно.
Төрийн өмчит дотоодын компанийн үйлдвэрлэлийн эрх	Энэ нь нийт үйлдвэрлэлд төрийн өмчит дотоодын компанийн эзлэх хувь хэмжээ бөгөөд тус компанийн эзэмшил хөрөнгөнөөс үүдэлтэй. Энэ урсгал нь бэлэн болон бэлэн бус хэлбэрийн алинаар нь ч байж болно.
Ашгийн татварууд	Компанийн үйлдвэрлэлийн өмнөх үйл ажиллагааны ашигт ногдуулсан татвар
Нөөц ашигласны төлбөр	Хүлээн авагч засгийн газар бүрийн нөөц ашигласны төлбөр тогтоох зохицуулалт харилцан адилгүй байдаг. Нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтуудад бүх үйлдвэрлэлийг явуулах үүрэг, борлуулалтын ашгийн тодорхой хэсэгт төлөх төлбөр зэрэг багтдаг. Нөгөө тохиолдолд, хүлээн авагч засгийн газар цаад үйлдвэрлэлийн тухайд шууд сонирхол ихтэй байдаг ба борлуулалтын зохицуулалтыг бие даан хийдэг. Эдгээр нөөц ашигласны төлбөр нь хүлээн авагч засгийн газрын үйлдвэрлэлийн эрхтэй илүү төстэй.
Ноогдол ашиг	Дотоодын төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд хувьцаа болон аливаа нэгэн хуваарилагдсан ашгаас засгийн газарт ноогдол ашиг төлдөг. Энэ нь өр төлбөр болон зээлийн хөрөнгөнөөс бусад бүх төрлийн хөрөнгөнд засгийн газарт ашиг хуваарилна гэсэн үг.

Ашиг орлогын урсгал	Нэмэлт тодорхойлолтууд
Шагнал (гарын үсэг, нээлт, үйлдвэрлэл зэрэгт олгодог)	Дараахь зүйлд урамшуулал олгоно: <ul style="list-style-type: none"> • Олборлох эрхээр шагнах, олгох болон түүнийг шилжүүлэхэд • Үйлдвэрлэлийн тодорхой түвшин болон тодорхой зорилтод хүрсэн тохиолдолд • Ашигт малтмалын нэмэлт нөөц\орд газар нээсэн тохиолдолд
Лицензийн хураамж, түрээсийн төлбөр болон лиценз, хөнгөлөлттэй холбоотой асуудлууд	Хүлээн авагч засгийн газарт болон дотоодын төрийн өмчит компанид дараахь тохиолдолд төлж байгаа төлбөрүүд: <ul style="list-style-type: none"> • Лиценз, хөнгөлөлт авсан газраа хайгуулын эрх авах, хайгуул хийж эхлэх(лиценз, хөнгөлөлтийн хураамж) • Хайгуулын ажил гүйцэтгэж, холбогдох мэдээлэл цуглуулах (оролтын хураамж). Эдгээр нь үйлдвэрлэлийн өмнөх шатанд хийгдэж болзошгүй лиценз, хөнгөлөлт бүхий газар нутгийг лизингээр буюу түрээсээр авах.
Хүлээн авагч засгийн газарт орох бусад томоохон хэмжээний ашиг орлого	Эдгээр ашиг орлогын урсгал нь компанийн орлого, үйлдвэрлэл буюу ашигт ногдуулсан татвараас бүрдэнэ. Үүнд хэрэглээнд ногдуулдаг татвар болох НӨАТ, хүн амын орлогын албан татвар, борлуулалтын татвар зэргийг оруулахгүй.

Ил тод байдлыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд томоохон зөрөөтэй байдал байнга үүсч байдаг бэлэн бус ашиг орлогын урсгалын хэмжээг тодорхойлох талаар онцгой анхаарал тавих хэрэгтэй. Жишээлбэл, Конго улсад бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу баррел тосны ашиг хуваарилалтыг тооцохын тулд доллараар гарсан зардлыг баррелаар гарсан зардалд шилжүүлдэг “төсвийн үнэ” (нэг баррелийн зөвшөөрөгдсөн үнэ)-ийг хэрэглэдэг. Иймэрхүү тохируулах үнийг тайлангийн маягтад хэрэглэхдээ хэн уг газрын тосыг зарсан, борлуулалтаас хэн ашиг хүртсэн, ямар үнээр зарсан, эдгээр үнийг төсвийн үнэтэй хэрхэн харьцуулж болох зэргийг тодорхойлсон баримт дагалдах ёстой. Үүний зэрэгцээ, уг баримтад төсвийн үнийг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн жишиг үнэтэй хэрхэн харьцуулахыг тодорхойлж болох юм.

Нэмэлт арга хэмжээ 17а. Сайн дурын үндсэн дээр тайлагнаж болох ашиг орлогын өөр ямар нэг нэмэлт урсгал байна уу?

Хэмжээний хувьд их биш боловч засгийн газар болон компаниуд өөрсдөө сайн дурын үндсэн дээр тайлагнахыг хүсч байгаа ашиг орлогын урсгалууд байж болох юм. Хэрэв тийм ашиг орлогын урсгалууд байгааг олж тогтоовол тэдгээрийг тайлагнах нь тухайн тайлан мэдээлэл хэрхэн ойлгогдох вэ гэдэгт ямар нэг байдлаар нөлөө үзүүлэхгүй байх талаас нь бодолцох ёстой.

Санал болгож буй арга хэмжээ 17б: Бүх компани тайлагнах нөхцлийг хэрхэн хангах вэ?

Засгийн газар бүх компани заасан хугацаанд, батлагдсан тайлангийн загварын дагуу тайлангаа ирүүлдэг байх нөхцлийг сайн хангах тал дээр онцгой анхаарал тавих ёстой. Үүнийг зарим оронд компаниудтай сайн дурын гэрээ хэлэлцээр хийх замаар хийж болох бол бусад оронд шинээр хууль эрх зүйн орчин бий болгох шаардлага тулгарч байж болно. ОСИТБС-ыг хэрэгжүүлж байгаа засгийн газар компаниудыг энэ чиглэлээр шахан хамтарч ажиллахын тулд өөрийн бүхий л хууль эрх зүйн чадамжаа дайчлах хэрэгтэй болдог. Түүнчлэн, ОСИТБС дээр хамтран ажиллах асуудлыг одоо үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдах компаниудтай ямар нэг гэрээ хийх нэг нөхцөл болгон авч үзэж ч болох юм.

ОСИТБС-ын тайлагнах шаардлага нь тухайн оронд үйл ажиллагаа явуулж буй бүх төрлийн олборлох үйлдвэрлэлийн компанид (олон улсын, дотоодын, төрийн өмчит) хамаатай байх ёстой. Тайлагнаж буй орлогын хэмжээ нь ямар ч тохиолдолд материаллаг бус гэдгийг бүх талаас нь өндөр магадлалтайгаар харуулж чадсан аж ахуйн нэгж л тайлагнах албанаас чөлөөлөгдөж болно.

Засгийн газар тэдгээр жижиг бизнес эрхлэгчдийн ашиг орлогын урсгалыг нэгтгэн тайлагнахыг хүсэж байж болох юм. Хэрэв энэ нь хүлээж авсан нийт орлогын үлэмж хэсгийг бүрдүүлж байвал зохих түвшиний босго тогтоох талаар зориуд анхаарах шаардлагатай болно.

Санал болгож буй арга хэмжээ 17в: Засгийн газар болон компаниуд яаж тайлагнах вэ?

Хүлээн авагч засгийн газар болон тайлагнагч компани хоёрын мэдээллийг харьцуулах боломж олгох үүднээс тайлангийн загварын төслийн тухай

гэрээнд ОСИТБС-ын тайланд хэрэглэх нягтлан бодох бүртгэлийн зарчим, аргуудыг авч үзэх шаардлагатай болно.

Нягтлан бодох бүртгэлийн үеүд, мөнгөн тэмдэгт болон мөнгөний нэгжүүдийн зөрөөтэй байдал нь засгийн газрын орлогын нэгдсэн дүн болон компанийн тушаасан нийт дүнгийн хооронд зөвшөөрсөн хэмжээнээс хол давж гарсан томоохон зөрөө үүсгэж болно. Энэхүү зохих ёсны зөрөөг багасгаж ил тод болгох ажил хойшлогдохоос сэргийлэхийн тулд эдгээр хувьсагч хэмжигдэхүүнийг харилцан зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн үйл явцаар дамжуулан стандартжуулах хэрэгтэй.

Хэрэгжилтийн явцад нэмэлт туршлага хуримтлагдахын хэрээр энэхүү заавар удирдамжид цаашид сайжруулах засвар өөрчлөлт хийгдэх болно.

Бүртгэлийн систем: Хэрэгжүүлэгч засгийн газрууд нь тодорхой хугацаанд компаниудаас орж ирэх төлбөрийн аккрузал хэмжээг тэр бүр тооцож чаддаггүй учраас бүх аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг бэлэн мөнгөний үндсэн дээр хөтөлж явуулах нь дээр байдаг.

Компаниудын тогтмол тайлан аккрузал суурьтай байх учир тэдгээр компанийн аудитуруудаас тохируулга хийсэн тайлбар мэдэгдлийг тайлангийнхаа нэг хэсэг болгон гаргаж өгөхийг хүсч болох юм. Энэхүү мэдэгдэл нь уг тайланд оруулсан бэлэн мөнгөний төлбөрийг санхүүгийн тайланд хэрхэн тохируулж тусгаснаа тайлбарласан тайлбар болдог.

Тайлагнах мөнгөний нэгж: Засгийн газар болон компаниуд тайлагнах мөнгөний нэгж дээрээ тохиролцох хэрэгтэй болно.

Уул уурхайн салбарын хувьд ихэнхи ашиг орлогын гүйлгээ нь дотоодын мөнгөний нэгжээр хийгддэг учир үүнийг бүртгэлийн нэгж болгон ашиглах, харин газрын тос, байгалийн хийн салбарт зах зээлийн нэрлэсэн үнэ нь ам.доллараар байдаг тул үүнийг бүртгэлийн нэгж болгон тус тус авч үзэхийг зөвлөж байна.

Хэдий тийм боловч тухайн улс ОСИТБС-ын төлбөр болон орлогыг өөрийн орны хүн амд илүү ойлгомжтой болгохын тулд дотоодын мөнгөний нэгж, ам.долларын аль алинаар нь хэвлэн нийтлэх шийдвэр гаргаж болно.

Бүртгэлийн нэгжээр дотоодынхоос өөр мөнгөний нэгж хэрэглэсэн гүйлгээний хувьд сар, улирлын валютын дундаж ханшийг ашиглан тухайн тайлангийн мөнгөний нэгжид шилжүүлэн тооцох нь зүйтэй.

Бүртгэлийн хугацаа: Газрын тос, байгалийн хий, уул уурхайн ихэнхи компаниуд дотооддоо сар, улирал тутамд тайлангаа гаргадаг боловч гадагшаа жилээр тайлагнадаг. Иймээс компаниудын хувьд эдгээр тайлант хугацааны аль нь илүү тохиромжтой байх талаар тохиролцоонд хүрэх хэрэгтэй болно.

ОСИТБС-ын тайлан нь дор хаяж жил тутам гардаг байх шаардлагатай ч зарим тохиолдолд жилд 2 удаа тайлагнах нь илүү тохиромжтой байдаг.

Бөглөгдсөн тайлангийн маягтуудыг хүргүүлэх: Тухайн үйл явцад итгэх итгэлийг төрүүлэх үүднээс компаниуд болон засгийн газар нь тайлангийн маягыг бөглөж дуусмагцаа аль болох хурдан, нэгэн зэрэг зохих журмын дагуу томилогдсон захирагчид хүргүүлэх нь зүйтэй.

Тайланг тодорхой хугацааны дотор цагт нь хийж гүйцэтгэх хэрэгтэй. Тайланг бэлтгэхэд хэдийчинээ их цаг зарцуулах тусам тайлагнасан төлбөр ба орлогын бодлогын хэлэлцүүлгэд ашиглагдах ач холбогдол нь төдий чинээ багасдаг.

Санал болгож буй арга хэмжээ 18. Төлбөр болон орлогын талаар мэдүүлсэн тайлангууд найдвартай, үнэн зөв үү?

ОСИТБС-ын үйл явцын итгэл даах чанар нь засгийн газар болоод компаниудаас захирагчид хүргүүлсэн төлбөр, орлогын тоо баримтын найдвартай байдлаас ихээхэн шалтгаалдаг.

Уг үйл явцыг одоо мөрдөгдөж буй дүрэм журам, байгууллагын тогтолцоо, олон улсын стандартад тулгуурлан явуулахыг аль болох эрмэлзэх нь зүйтэй. Практик үйл явц нь дараахь байдлаар тодорхойлогдоно:

- Компаниуд тэднийд аудит хийж байгаа хөндлөнгийн аудитороос тус компанийн ОСИТБС-д хүргүүлэхээр төлөвлөж буй мэдээлэл нь тэдний санхүүгийн тайлантай нийцэж байгаа гэсэн дүгнэлт авах ёстой. Энэ нь хөндлөнгийн аудиторын ажлын удирдамжинд хавсаргасан “тусгай журам” байж болох юм. Хөндлөнгийн аудиторууд нь компанийн бэлэн мөнгөөр гаргасан мэдээллүүдийг аккруэл суурьтай санхүүгийн тайлантай нь харьцуулан үзэх болно. Энэ ажлыг аудитын тухай олон улсын зохих стандартын дагуу хийнэ.
- Үүнтэй нэгэн адилаар засгийн газрын аудитор нь засгийн газраас хүргүүлсэн орлогын тайлан үнэн зөв эсэх талаар дүгнэлт гаргаж өгөх ёстой.

Санал болгож буй арга хэмжээ 18а. Төлбөр, орлогуудад хараат бус, аудит хийх итгэмжлэгдсэн аудит байхгүй бол тийм аудит хийх компани эсвэл компаниудыг олж тогтоосон уу?

ОСИТБС-ын хүрээнд тайлагнасан бүх төлбөр, орлого нь хараат бус, итгэмжлэгдсэн аудиторроор шалгагдсан байх ёстой. Ердийн үед бол компаниуд өөрийн хараат бус аудиторроор баталгаажуулсан төлбөрийн тоо баримтаа хүргүүлсэн бол түүнд өөр аудит хийх шаардлагагүй байдаг. Харин тийм аудит хийлгээгүй, эсвэл уг аудит нь итгэж болохооргүй гэж үзвэл нэмэлт аудит хийлгэх хэрэгтэй. Тухайн томилогдох аудиторын хувьд хараат бус, өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулах нь илүү зохистой байж болно.

Жишээ 19

Азербайжанд аудиторын хорооноос тайлангуудад илэрсэн, зөвшөөрөгдсөн хязгаараас давсан зөрөөтэй, уялдаа холбоогүй байдлыг хэрхэн зохицуулах талаар журам гаргадаг.

а. Хэрэв зөрүүтэй байдал илэрвэл тус хороо нийт дүнгээр нь болон компани бүрээр задлан гаргасан нарийвчилсан шинжилгээг аудитын компанид гаргаж өгнө.

б. Хэрэв илэрсэн асуудал үүгээр шийдэгдэхгүй бол аудитын компани уг зөрөөтэй байдлыг холбогдох нягтлан бодох бүртгэлийн байгууллагад мэдэгдэж тоо баримтаа нотлох нэмэлт баримтууд ирүүлэхийг шаардана.

Санал болгож буй арга хэмжээ 19. Захирагч ОСИТБС-ын тайланг хэрхэн гаргах вэ?

Эхний шатанд томилогдсон захирагч нь компани, засгийн газрын тайлангуудыг хүлээн аваад тэдгээр нь хоорондоо тохирч байгаа эсэхийг харьцуулж үзнэ. Энэ нь хэрэгжүүлэгч орны ОСИТБС-ын тайлангийн үндэс болно. ОСИТБС-ын тэрхүү тайланг хөндлөнгийн аудиторын дүгнэлт гаргуулахаар хүргүүлж болно.

ОСИТБС-ын тайланд илэрсэн алдаа, зөрөөтэй байдлыг авч хэлэлцэх журмыг тохирох ёстой. Хэрэв тайлангуудыг харьцуулан үзээд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг тухайн компанийн хөндлөнгийн аудитор эсвэл засгийн газрын аудиторын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ. Хэрэв томоохон зөрөө гарсан хэвээр байвал цаашид ямар арга хэмжээ авахыг авч үзэх шаардлагатай.

Нэмэлт арга хэмжээ А19а. Тайлан гаргах явцад гарч болох алдааны зөвшөөрөгдөх түвшинг тогтоосон уу?

Стандартчилагдсан тайлангийн үйл явцыг тохирсоны дараа, гэхдээ хэрэгжилтийн шатны өмнө, олборлох салбарын төлсөн төлбөр ба тухайн засгийн газрын хүлээн авсан олборлолтын орлогын хоорондох тухайн захирагчийн олж илрүүлсэн ямар нэг зөрөөтэй байдалд байж болох алдааны зөвшөөрөгдсөн түвшингийн талаар гол оролцогч талууд хэлэлцэн тохироно.

Аливаа шинэ хөтөлбөр, санаачилгууд нь хэрэгжилтийн эхний шатандаа алдаа дутагдал ихтэй байдаг гэдгийг үндэслэн зарим ОСИТБС-ын оролцогчид эхний тайлангийн зөвшөөрөхүйц алдааны хязгаарын хэмжээ нэг бол арай

илүү байх ёстой эсвэл олон нийтийг хамарсан зохисгүй шуугиан гарахаас сэргийлэх, “зохих ёсны зөрөөтэй байдлыг” олж тогтоон зохицуулах үүднээс эхний тайланг “туршилтын” байдлаар хэвлэн нийтлэхгүйгээр бэлтгэн гаргах хэрэгтэй гэж үздэг.

Нэмэлт арга хэмжээ А19б. Ихэнх оролцогчид шаардсан тохиолдолд тайлангийн тоо баримтад хараат бус аудит хийх зохицуулалт хийгдсэн үү?

Зарим оронд одоо гүйцэтгэж байгаа аудитуудад итгэх итгэл болон тайлангийн үйл явцын талаархи асуудлууд нь оролцогч талуудыг засгийн газар болон компаниудын гаргаж өгсөн төлбөр, орлогын тоон баримтуудыг цуглуулан үнэлэх хараат бус, бие даасан аудитор томилох хүсэлт гаргахад хүргэж болно.

Өмнө нь аудит хийгдсэн тайлангуудад дахин аудит хийхгүй байх шийдвэр гарсан байлаа ч гэсэн хэрэв төлбөр, орлогын тайлангийн зөрүүтэй байдлыг харьцуулж үзэх шаардлагатай бол захирагч засгийн газар болон компаниудаас тоо баримтыг дахин авч болохгүй гэх үндэслэл байх ёсгүй.

Санал болгож буй арга хэмжээ 20. ОСИТБС-ын тайланг хэрхэн ил тод болгох вэ?

Оролцогчид ОСИТБС-ын хэрэгжилтийн үр дүнг хэн ил тод болгох вэ гэдгээ тохирох хэрэгтэй. Зарим тохиолдолд захирагч ийм үүрэгтэй байж болох боловч өнөөгийн байдлаар ихэвчлэн янз бүрийн байгууллага ийм шийдвэр гаргах үүрэгтэй байна.

Хэрэгжилтийн үр дүнг ямар байгууллага ил тод болгохоос үл хамааран, ОСИТБС-ын ихэнх гол оролцогчид тэрхүү байгууллага, хувь хүнийг хараат бус, итгэлийг хүлээхүйц гэж үзэх нь чухал. Цаашилбал, тэдгээр нь хэрэгжилтийн үр дүнг нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар ил гаргаж тавих, хүргэх чадвар, чадавхитай байх хэрэгтэй.

Санал болгож буй арга хэмжээ 20а. ОСИТБС-ын тайланг нэгдсэн эсвэл хэсэгчлэн задласан байдлаар хэвлэн нийтлэх ёстой юу?

Оролцогчид, компанийн болон хүлээн авагч засгийн газрын тайлангуудыг нэгдсэн эсвэл хэсэгчлэн задласан байдлын алинаар нь олон нийтэд хүргэхээ тохиролцох ёстой. Энэ талаархи эцсийн шийдвэрийг хүлээн авагч засгийн газар өөрөө гаргана.

Жишээ 20

Киргизийн Нягтлан Бодох Бүртгэлийн Танхим нь засгийн газар, компани хоёрын тайлангийн зөрүүний зөвшөөрөгдөх хэмжээ нь 1%-с хэтрэх ёсгүй гэж тохирчээ.

Жишээ 21

Нигери улсад олон нийтийн итгэлийг хүлээх үүднээс ОСИТБС-ын хүрээнд тайлагнасан төлбөрүүдэд аудит хийхээр бүх оролцогч талууд тохирсон байна. Аудиторыг сонгон шалгаруулах үйл явцын талаар тохиролцоонд хүрсэн бөгөөд хараат бус аудиторуудыг сонгон шалгаруулахад олон нийтийн нээлттэй тендер зарлахаар болсон байна.

Жишээ 22

Киргизд мэдээллийг ил тод болгох нь Статистикийн Комиссын чиг үүрэг байхад Азербайжанд үүнийг Үндэсний ОСИТБС-ын Комисс хариуцдаг. Нигери улсад ийм төрлийн шийдвэрийг Үндэсний Оролцогчдын Ажлын Хэсэг гаргадаг.

Жишээ 23

Азербайжанд компаний нууцлалын тухай асуудал тавигдсанаар тайлангийн эхний үед нэгтгэсэн байдлаар гаргах аргыг ашиглахад хүргэсэн. Киргизэд тухайн салбарт ганц компани ноёрхож байгаа учраас нэгтгэж гаргах асуудал нь тийм ч чухал биш байна.

Жишээ 24

Нигерийн оролцогчид ил тод болгох байгууллага нь ил тод байдал, ОСИТБС-ын ойлголтыг нэмэгдүүлэх янз бүрийн хөтөлбөрүүдийг аль алийг нь зохион байгуулах ёстой гэж санал болгосоны дотор телевизийн мэтгэлцээн, үндэсний хэлээр явуулдаг радиогийн нэвтрүүлэг, вэб сайт, гарын авлага, дунд болон их дээд сургуулиудад зохиох семинарууд орж байна.

Жишээ 25

Гана улсын ОСИТБС-ын тайлагнах удирдамж ёсоор хэрэгжилтийн үр дүн нь уул уурхайн салбарын талаар боломжийн мэдлэгтэй хэрэглэгчдэд шууд ойлгогдож байх ёстой... мөн өгөгдсөн мэдээллийг тодорхой хэмжээнд анхааралтай уншиж судлах сонирхолтой байх ёстой ажээ. Нигери дэх зөвлөлдөх ажлын хэсэг “үр дүн нь баримттай, хялбар ойлгож болохуйц, энгийн байх ёстой” гэж заажээ. Мөн Азербайжаны эвсэлийнхтэй адилаар үр дүнгийн тайланг тусгай тайлбарт гарын авлага дагалдах ёстой гэж санал болгожээ.

Нэгдсэн байдлаар ил тод болгоно гэдэг нь ашиг орлогын урсгал бүрт нэг л тоог олон нийтэд хүргэхийг хэлнэ. Энэ тохиолдолд уг тоог нэгтгэн гаргах үйл явц найдвартай, итгэж болохуйц байсан эсэхэд онцгой анхаарах хэрэгтэй.

Хэсэгчлэн задласан байдлаар ил тод болгоно гэдэг нь бүх компани болон лицензийн тоогоор задлан гаргахыг хэлнэ. Энэ тохиолдолд задалж гаргасан тоонууд нь хоорондоо харьцуулж болохуйц, утга төгөлдөр байгаа эсэхэд онцгой анхаарах шаардлагатай.

Илүү ил тод байдалд хүрэхийн тулд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журам, гэрээ хэлэлцээрүүдийг хүндэтгэн үзэх нь ОСИТБС-ын нэг баримтлах зарчим юм. Мэдээллийг ОСИТБС-ын хүрээнд ил болгох асуудал, компаниудын бизнесийн нууцтай холбоотой асуудал хоёрын хоорондын тэнцвэрийг барихад онцгой анхаарал тавих ёстой.

Д. Олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх

Санал болгож буй арга хэмжээ 21. ОСИТБС-ын үр дүн нь хүртээмжтэй, ойлгомжтой байна уу?

ОСИТБС-ыг бүрэн хэрэгжүүлнэ гэдэг нь төлбөр болон орлогын бүхий л мэдээллийг өргөн олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой, энгийн байдлаар ил болгохыг хэлнэ.

Олон оронд ОСИТБС-ын тайлан нь үндэсний ОСИТБС-ын вэб сайтад тавигдах ёстой байдаг. Янз бүрийн оролцогчид мэдээллийг янз бүрийн байдлаар олж авдаг учраас үр дүнг танилцуулах үйл явцад энэ онцлогийг харгалзаж үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, үр дүнг танилцуулан түгээхдээ янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор сонин хэвлэл, телевиз, радио, дотоодын семинар зэргийг ашиглах ёстой.

Санал болгож буй арга хэмжээ 21а. Тайлангийн үр дүнг өргөн хүрээтэй тарааж танилцуулах тогтсон заавар журам бий юу?

Хэрэв аль нэг улс өөрийн ОСИТБС-ын хэрэгжилтээ мэдээллийг ил тод болгох техник дасгалаас илүүтэй дээд шатанд гаргая гэвэл үр дүнгээ газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас олох орлого нь эргээд өргөн хүрээтэй санхүүгийн удирдлагын асуудлууд болж хөндөгдөх хэмжээнд хүртэл өргөнөөр тараан танилцуулах явдал чухлаар тавигдана.

Засгийн газрууд нээлттэй төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнах тухай ОУВС-гийн Төсвийн Ил Тод Байдлын Тэргүүн Туршлагын Кодод заасан зарчмуудыг хэрэгжүүлэх, үүндээ нэмэлт болгож сайтар чиглүүлэн зохион байгуулагдсан бүх нийтийн хэвлэн нийтлэх кампанит ажил явуулах нь зүйтэй.

ОСИТБС-ыг хэрэгжүүлж эхэлсэн ихэнх улс орнууд мэдээллийн чанартай янз бүрийн семинарыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр уг асуудлаар хариуцлагатайгаар тайлагнах явдлыг хөхиүлэн дэмжих юм. Үр дүнг оролцогчдод ойлгуулахад хэл чухал үүрэгтэй учир шаардлагатай бол тухайн улсын хэл рүү орчуулга хийх хэрэгтэй болно.

Санал болгож буй арга хэмжээ 22. Төлбөр ба орлогуудын тайлагнасан үр дүнгийн талаар гол оролцогч нарыг оролцуулан ямар нэгэн хэлэлцүүлэг хийсэн үү?

Үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэсний дараа засгийн газар тайлагнасан орлогынхоо талаар олон нийтийг хамарсан хэлэлцүүлгийг өөрөө санаачлан зохион байгуулах хэрэгтэй. ОСИТБС-ыг үр нөлөөтэй болгохын тулд гол оролцогч талууд нь үр дүнг хэлэлцэн, үнэлж, тайлбарлаж чаддаг байх хэрэгтэй. Ийм хэлэлцүүлэг нь засгийн газар олборлох үйлдвэрлэлийн орлогыг хариуцан ажиллахад бэлэн, үүнийхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай гэдгээ харуулах дохио болно.

Нэмэлт арга хэмжээ А22. Тэрхүү хэлэлцүүлэгт өргөн хүрээтэй олон оролцогчдыг хамруулсан уу?

Хэлэлцүүлэгт оролцсоноор тухайн үйл явцыг улам баяжуулах бусад сонирхогч талууд байж болох юм. Боломжтой бол эдгээр оролцогчдод гол санааг танилцуулж, тоон мэдээллийг тайлбарлан ойлгуулахад туслах механизмуудаар хангаж өгөх нь чухал. Тэдний саналыг нэгтгэн тусгах механизм бий болгох нь өргөн олны дэмжлэг хүлээх, тухайн үйл явц ба түүнд оролцогч байгууллагуудын хууль ёсны байдлыг бэхжүүлэхэд тус дөхөм болох юм.

Жишээ 25

Гана улсын ОСИТБС-ын тайлагнах удирдамж ёсоор хэрэгжилтийн үр дүн нь уул уурхайн салбарын талаар боломжийн мэдлэгтэй хэрэглэгчдэд шууд ойлгогдож байх ёстой. Мөн өгөгдсөн мэдээллийг тодорхой хэмжээнд анхааралтай уншиж судлах сонирхолтой байх ёстой ажээ. Нигери дэх зөвлөлдөх ажлын хэсэг “үр дүн нь баримттай, хялбар ойлгож болохуйц, энгийн байх ёстой” гэж заажээ. Мөн Азербайжаны эвсэлийнхтэй адилаар үр дүнгийн тайланг тусгай тайлбарт гарын авлага дагалдах ёстой гэж санал болгожээ.

Жишээ 26

Киргизэд Сангийн Яам нь өөрийн санхүүгийн удирдлагын талаар олон нийттэй харилцах, тэднээс санал авахад туслах зорилгоор харилцааны газар байгуулахаар болж байна.

ОСИТБС-ын хэрэгжилтийг үнэлж дүгнэх

Е. Үнэлэлт дүгнэлт

Санал болгож буй арга хэмжээ 23. ОСИТБС-д хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тогтсон зохицуулалт байна уу?

ОСИТБС-ын үйл явцыг үнэлж дүгнэх нь тухайн улс оронд уг санаачилгыг хэрэгжүүлснээр ямар ашиг тус олов гэдгийг үнэлэх, тус улс хэр зэрэг сайн ажиллаж байгааг бусад оронд харуулах, хэрэгжилтийг цаашид сайжруулахад гол анхаарлаа хандуулахад тустай байдаг. Гол оролцогч талууд хэрэгжилтийг хянах нөхцлүүдийг боловсруулаад зогсохгүй санал асуулга явуулах, ярилцлага хийх зэргээр өөрсдөө хяналтанд оролцох нь чухал. Энэхүү үе шат нь иргэний нийгмийн байгууллагуудад засгийн газартай ойр дотно ажиллах, үйл явцад нэмэлт хяналт тавих боломж олгодог.

Нэмэлт арга хэмжээ А23а. Албан ёсны, хараат бус үнэлгээний механизм байна уу?

Албан ёсны, хараат бус үнэлгээний механизмтай байхын давуу тал бол энэ нь дотоодын болон олон улсын оролцогч нарын аль алинд нь ОСИТБС-ын үйл явцад итгэх итгэл төрүүлдэг явдал юм. Хараат бус үнэлгээ өгөгч нь “Уг үйл явц тогтвортой байж чадах уу?”, “Засгийн газар, үйлдвэрлэлийн салбар, иргэний нийгмийн үүрэг ролийг сайжруулах талаар ямар сургамжууд авч болох вэ?” зэрэг чухал асуултад хариулт өгч чадахуйц тайлан бэлтгэдэг.

Нэмэлт арга хэмжээ А23б. Хэрэгжилтээс олж авсан сургамжуудыг бусад улс орон, оролцогчидтой хуваалцсан уу?

Олж авсан туршлагаа ОСИТБС-ыг хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа улсуудтай хуваалцах нь тэдгээр оронд тустай төдийгүй мөн түүнчлэн авч хэрэгжүүлсэн шинэтгэлдээ үнэлгээ авах бололцоо олгодог юм. ОСИТБС-ын Нарийн Бичгийн Дарга нарын газар нь бүсийн болон олон улсын хэмжээний семинар зөвлөгөөн зохион байгуулах, гарын авлага болон ОСИТБС-ын вэб сайтыг шинэчлэх замаар олж авсан сургамжуудыг бусадтай хуваалцах үйлчилгээний төвийн үүрэг гүйцэтгэх болно.

Санал болгож буй арга хэмжээ 24. Шийдвэр гаргах журам болон бусад ажиллагааг боловсруулахад эргэх холбооны механизмууд нөлөөлсөн үү?

ОСИТБС-ын хэрэгжилт нь олж авсан туршлагынхаа хэрээр тасралтгүй сайжран хөгжих болно. Энэ нь хийснээсээ суралцах үйл явц юм. Хэрэгжилтийг үр нөлөөтэй, тогтвортой болгохын тулд оролцогч талуудынхаа саналыг харгалзаж үзэх, зохих эргэх холбооны мэдээллийг ашиглах шаардлагатай.

БҮЛЭГ 3

Олборлох салбарын компаниудад зориулсан заавар удирдамж

Ерөнхий тойм

ОСИТБС нь холбогдох байгалийн нөөц баялаг ихтэй орнуудын хийх ажил юм. Гэхдээ ОСИТБС-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд компаниуд ихээхэн шийдвэрлэх үүрэгтэй гэж уг санаачилга үзэж байгаа юм. Энэхүү заавар удирдамж нь олон улсын, дотоодын, төрийн өмчийн, хувийн гэхчилэн бүх компанид ямар нэгэн ялгаваргүйгээр зориулагдсан боловч энд санал болгож буй зарим нэмэлт арга хэмжээ нь аль нэг компанид тохирохгүй байж болох талтай. Энэ талаар уг сурвалж бичгийн дараагийн дэвтэрт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Энэхүү заавар удирдамжид олборлох салбарын компаниудын гүйцэтгэж болох янз бүрийн үүргийг харуулсан. Мөн энд тэдний ОСИТБС-ыг баталгаажуулах үүргийг үндэсний хэмжээний дэмжлэг (хэрэгжүүлэгч болон хэрэгжүүлэгч бус орнуудын аль алинд нь) үзүүлэх үүргээс нь салгаж авч үзлээ.

Компанийн үйл ажиллагаа болон нэмэлт арга хэмжээний хураангуй

ОСИТБС-ын сайн дурын шинж чанарыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ ОСИТБС-ыг дэмжих чиглэлээр компанийн зүгээс хэрэгжүүлж болох арга хэмжээг олж мэдэхийг хүссэн олборлох салбарын компанийн (болон бусад оролцогчийн) хүсэл эрмэлзлийг харгалзан үзсэний үндсэн дээр энэхүү номонд ОСИТБС-ыг дэмжиж байгаа компани түүний хэрэгжилтийг улам үр дүнтэй болгохын тулд авбал зохих арга хэмжээ, мөн хэрэгжилтийг сайжруулахын тулд авч болох нэмэлт арга хэмжээг тус тус үзүүлэв. Эдгээр арга хэмжээ нь байгалийн нөөц баялаг ихтэй орнуудад зориулсан заавар удирдамжид тодорхойлсон үр дүнг дэмжих зорилготой юм.

Компаний арга хэмжээ

Нэмэлт арга хэмжээ

Баталгаажуулалт

А. Гарын үсэг зуран элсэх

25. Компани ОСИТБС-ын хэрэгжилтийг дэмжих бодолтой байгаа талаараа тодорхой мэдэгдэл хийсэн үү?

A25. ОСИТБС-ыг бодлого болон дотоод тайландаа оруулж тусгасан уу?

26. Компани ОСИТБС-ын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах хүнээ томилсон уу?

Б. Олон улсын дэмжлэг

- Бага хурлуудад оролцож үг хэлэх;
- Дотоод, гадаадын хурал семинарт орлогын ил тод байдал, түүний удирдлага, ОСИТБС-ын талаар үг хэлэх;
- ОСИТБС-ын хэрэгжилтийн удирдамж болсон гол баримт бичгүүдийг эргэж харах талаар санал шүүмжлэл гаргах;
- ОСИТБС-ын тэргүүн туршлагын жишээг олж авах, дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэхэд туслах;
- ОСИТБС-ыг өөрийн болон бусад улс орны засгийн газарт тэдний стратегийн харилцаа холбооны нэг хэсэг болгож тавих;
- ОСИТБС-ын аргыг салбарын тэргүүн туршлага, заавар удирдамж болгон ашиглах явдлыг дэмжих, ийм хүчин чармайлтыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах.

- Орлогын ил тод байдлыг дэмжих талаар хувьцаа эзэмшигчидтэй идэвхтэй харилцах;

Үндэсний хэмжээний дэмжлэг

27. Компани олон улсын стандартын дагуу аудит хийлгэдэг үү?

A27. Компани ил тод байдлыг дээшлүүлэхийг дэмжих талаар бусад компанид уриалсан уу?

B1. Хэрэгжүүлэгч орон

28. Компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнуудад уг санаачилгыг хэрэгжүүлэх эхлэлийг тавих ажилд нь бүрэн оролцсон уу?

29. Компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнуудад уг санаачилгыг хэрэгжүүлэхэд нь бүрэн оролцсон уу?

30. Компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнуудад уг санаачилгын хэрэгжилтийг үнэлж дүгнэх ажилд бүрэн оролцсон уу?

B2. Хэрэгжүүлэгч бус орон

- Ил тод байдлын талаар хандивлагчид, олон улсын санхүүгийн байгууллагуудтай ярилцах;
- Семинар зохион байгуулах.

Баталгаажуулалт

А. Гарын үсэг зуран элсэх

Компанийн арга хэмжээ 25. Компани ОСИТБС-ын хэрэгжилтийг дэмжих бодолтой байгаа талаараа тодорхой мэдэгдэл хийсэн үү?

Олборлох салбарын бүх компани ОСИТБС-ын зарчим, шалгууруудыг батлахыг дэмжих хэрэгтэй. Түүнчлэн компаниуд ОСИТБС-ыг хэрэгжүүлэх сонголт хийсэн улс орныг дэмжихэд бэлэн байгаагаа илэрхийлэх нь зүйтэй. Санаачилгыг хэрэгжүүлэх гол үүрэг хариуцлага тухайн оронд өөрт нь ноогдох учиртай тул хэрэгжүүлэгч оронд дарамт шахалт үзүүлэхээс компаниуд аль болох зайлсхийх хэрэгтэй.

Мэдэгдлийг компанийн гүйцэтгэх дээд удирдлага эсвэл зохих эрх бүхий төлөөлөгч хийх бөгөөд уг мэдэгдлээ тухайн компанийн вэб сайтад тавих буюу жилийн тайландаа оруулах хэрэгтэй. Мөн мэдэгдлийн нэг хувийг олон улсын ОСИТБС-ын нарийн бичгийн дарга нарын газарт илгээж тэдний вэб сайтад байрлуулна. Мэдэгдэлд ОСИТБС-ыг хэрэгжүүлэх талаар идэвх зүтгэл гаргаж байгаа болон энэ чиглэлийн үйл ажиллагааг нь дэмжих сонирхолтой байгаа улсуудынхаа жагсалтыг оруулж болох юм.

Компанид зориулсан нэмэлт арга хэмжээ А25. ОСИТБС-ыг бодлого болон дотоод тайландаа оруулж тусгасан уу?

Тухайн компани ОСИТБС-ын зарчим болон шалгууруудыг өөрийн бодлого, дотоод тайландаа тусгахыг хүсэж байж болох юм. Үүний сацуу, компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнуудад ОСИТБС-ын хэрэгжилтийг хэрхэн дэмжих талаар өөрийн ажилтнуудад мэдээлэл өгч болох юм.

Компанийн арга хэмжээ 26. Компани ОСИТБС-ын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах хүнээ томилсон уу?

Компани зохих дээд түвшиний хүнээ тухайн компанийн хүрээнд ОСИТБС-ын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, энэ талаарх мэдлэг мэдээллийг сайжруулах ажил үүргийг хүлээлгэн томилох ёстой. Мөн өөрийн вэб сайтад тэрхүү томилогдсон хүний нэр, холбоо барих хаяг зэргийг тавьж болох юм.

Б. Олон улсын дэмжлэг

Компаниуд өөрийн удирдах төв байр эсвэл олон улсын түвшинд ОСИТБС-ыг хөгжүүлэх, сайжруулах ажлыг янз бүрийн арга хэмжээ авах замаар дэмжиж болно. Үүнд:

- Дотоод, гадаадын хурал уулзалт дээр орлогын ил тод байдал болон ОСИТБС-ын тухай ярих;
- ОСИТБС-ын хэрэгжилтийг гол удирдамжаар хангадаг үндсэн баримт бичгүүдэд засвар өөрчлөлт оруулах талаар санал шүүмжлэл гаргах;
- ОСИТБС-ын тэргүүн туршлагын жишээг олж авах, дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэхэд туслах;
- ОСИТБС-ыг өөрийн болон бусад улс орны засгийн газруудад тэдний стратегийн харилцаа холбооны нэг хэсэг болгон тавих;
- Орлогын ил тод байдлыг дэмжих талаар хувьцаа эзэмшигчидтэй идэвхтэй харилцах;
- ОСИТБС-ын аргыг салбарын тэргүүн туршлага, заавар удирдамж болгон ашиглах явдлыг дэмжих, ийм хүчин чармайлтыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах.

Үндэсний хэмжээний дэмжлэг

Компанийн арга хэмжээ 27. Компани олон улсын стандартын дагуу аудит хийлгэдэг үү?

Олон улсын компани нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас (ЭЗХАХБ) гаргасан Компанийн Засаглалын зарчмуудад тодорхойлсон аудиттай холбоотой ил тод, нээлттэй байдлын шаардлагыг харгалзаж үзэх ёстой. Түүнчлэн эдгээр компани нь өөрийн хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн шаардлагын дагуу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартууд, түүний дотор, тухайлбал, 2001 онд Газрын Тосны Салбарын Нягтлан Бодох Бүртгэлийн Хорооноос Зөвлөмжилсөн Практикийн Мэдэгдэлд заасан зөвлөмжийг дагаж мөрддөг байх ёстой.

ОУВС-гийн удирдамжийн төсөлд дотоодын болон төрийн өмчит компанид компанийн аудитын стандарт шаардлагыг дагаж мөрдөхийг зөвлөмж

болгосон бөгөөд мөн төрийн өмчийн газруудад аудит хийх эрхтэй тохиолдолд аудитын дээд байгууллагаар хянуулах хэрэг гарч болох юм.

Хүлээн авагч орны явуулж буй ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн аливаа арга хэмжээнд компани ямагт эерэгээр, олон нийтэд дулдуйдах байдлаар хандаж байх ёстой. Шаардлагатай бол тухайн оронд үйл ажиллагаа явуулж байгаа бусад компанитай энэ талаар түншилж болно.

Компанид зориулсан нэмэлт арга хэмжээ А27. Компани ил тод байдлыг дээшлүүлэхийг дэмжих талаар бусад компанид уриалсан уу?

Зарим компани хүлээн авагч орноос явуулж буй арга хэмжээнд эерэгээр хандахдаа эдгээр оронд үйл ажиллагаа явуулж байгаа бусад компанийг уриалан оролцож чадахуйц байр суурьтай байдаг. Ингэснээрээ тэд хүлээн авагч засгийн газрын эдийн засагт өөрийн салбарын оруулж буй хувь нэмрийг бүрэн дүүрэн харуулж байгаа хэрэг болох юм. Ийм байдал нь магадгүй тухайн компанийн аль нэг улс оронд эзэлж байгаа байр суурьтай холбоотой эсвэл түүний хамтарсан үйлдвэрүүдийнхээ хувьд гүйцэтгэх үүрэгтэй нь холбоотой байж болно. Аливаа хүлээн авагч засгийн газар ОСИТБС-ыг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан тохиолдолд ОСИТБС-ыг сайн мэдэх туршлагатай компаниуд тухайн оронд үйл ажиллагаа явуулдаг, энэ санаачилгын талаар сайн мэдэхгүй бусад компанидаа зааж сургах үүрэг хүлээх ёстой.

В1. Хэрэгжүүлэгч улс

Тайлан гаргах ажилд ОСИТБС-ыг хэрэгжүүлэгч орон дахь олборлох салбарын бүх компанийг хамруулах нь ОСИТБС-ын зарчмуудын нэг юм. Тогтоосон хугацаанд бүх компани тайлангаа ирүүлдэг байх нөхцлийг хэрхэн сайтар хангах талаар хүлээн авагч орон шийдвэр гаргах ёстой. Тухайн орны онцлог нөхцөл байдлаас үүдээд энэ нь сайн дурын зохицуулалт эсвэл хууль эрх зүйн хүрээ шинээр бий болгох асуудал байж болно [улсуудад санал болгож буй арга хэмжээ 17б]

Тухайн компанийн үйл ажиллагаа явуулж байгаа улс ОСИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдвэл тус орны энэхүү хүчин чармайлтад анхнаасаа оролцоно гэж үзэж болно. Компанийн хүлээх гол үүрэг бол зөвшөөрөгдсөн тайлангийн маягтыг бөглөх (В,Г хэсэг дэх улс оронд санал болгож буй арга хэмжээг үз) явдал юм. Үйл явцад оролцогчийн хувьд ихэнх компани хэрэгжилтийн бусад хүчин зүйлст бас хамрагдах ёстой байдаг.

Компанийн арга хэмжээ 28: [Улсын хувьд эхлэлт]: Компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнуудад уг санаачилгыг хэрэгжүүлж эхлэх ажилд бүрэн оролцсон уу?

Хэрэгжүүлж эхлэх ажилд бүрэн оролцохын тулд:

- Компани ОСИТБС-ын тайлангийн маягтыг бөглөх болон ОСИТБС-ын бусад үйл ажиллагаанд оролцоход гарах зардлаа тооцож гаргасан уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 15] Ийм зардалд шууд гарах зардлууд, чадавхийг бэхжүүлэх зардлууд болон ажилтны цалин гэх мэт шууд бус зардлууд багтана.
- Захирагч болон аудиторыг сонгож томилоход тус компани оролцсон уу? (тухайн оронд санал болгосон арга хэмжээ B13)
- Компани орлогын ил тод байдлын талаарх ойлголтоо бусад оролцогчидтой хуваалцахад оролцсон уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээний дэмжлэг 11]
- Компани чадавхийг бэхжүүлэх хэрэгцээгээ тодорхойлоход бусад оролцогчидтой хамтран оролцсон уу? Тус компани тухайн оронд санал болгох арга хэмжээ 16-д ямар дэмжлэг үзүүлэхээ шийдсэн үү?

Компанийн арга хэмжээ 29: [Улсын хувьд хэрэгжүүлэлт]: Компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнууддаа уг санаачилгыг хэрэгжүүлэхэд бүрэн оролцсон уу?

ОСИТБС-ыг хэрэгжүүлэхэд бүрэн оролцоно гэдэг нь дараахь байдлаар тодорхойлогдоно:

- Тайлангийн маягтыг боловсруулах талаар засгийн газартай хийсэн яриа хэлэлцээнд тус компани оролцсон уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 12]
- Нэгдсэн эсвэл хэсэгчлэн задласан байдлаар мэдээллийг ил тод болгох талаар шийдвэрээ гаргасан уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 20a]
- Ашиг орлогын ямар урсгалыг тайлагнах талаар тохиролцоонд хүрч чадсан уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 17a]
- Мэдээллийн задаргааны (засгийн газрын түвшнээр, төлбөрийн нэр төрлөөр, үйлдвэрлэлийн нэр төрлөөр, нөөц ашигласны төлбөр,

хураамжуудаар г.м) талаар тохиролцоонд хүрч чадсан уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 17а]

- Компанийн мэдээлэл тогтсон загвараар гарч байна уу? Жишээлбэл, тогтсон систем, хугацаа, үндэслэл, нэгжийн дагуу гарч байна уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 17в]
- Компани хэрэгжүүлэгч оронд төлсөн төлбөрийн тайландаа аудит хийлгэх хөндлөнгийн аудитор ажиллуулах зохицуулалт хийсэн үү? [ОСИТБС-ын шалгуур 2]
- Компани хэрэгжилтийн үр дүнг ил тод болгох итгэл хүлээсэн, хараат бус агентлагийг томилоход оролцсон уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 20]
- Компани хэрэгжилтийн үр дүнг олон нийтэд тарааж танилцуулах, хэлэлцүүлэх ажилд оролцсон уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 22]

**Компанийн арга хэмжээ 30: [Улсын хувьд үнэлэлт дүгнэлт]:
Компани ОСИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй орнуудад уг санаачилгын хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд бүрэн оролцсон уу?**

Үнэлэлт дүгнэлтэд бүрэн оролцохын тулд дараахь арга хэмжээг авсан байна:

- Компани үнэлэлт дүгнэлтийн нөхцөл шаардлагыг боловсруулахад оролцсон уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 23]
- Компани ОСИТБС-д оролцсоноор олж авсан туршлага, сургамжуудаа боловсруулж, үндэсний болон олон улсын хэмжээнд бусадтайгаа хуваалцсан уу? [тухайн оронд санал болгож буй арга хэмжээ 23, нэмэлт арга хэмжээ А23б]

В2. Хэрэгжүүлэгч бус орон

- Ил тод байдлын талаарх яриа хэлэлцээ нь ихэвчлэн засгийн газар хоорондын түвшинд эсвэл засгийн газар ба олон улсын байгууллагуудын түвшинд явагддаг талтай учраас компани ил тод байдлын асуудлыг хандивлагчид болон олон улсын байгууллагуудад тавьж тус компани ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг дэмжиж байгаа гэдгээ харуулж болох юм.

Нэр томъёоны тайлбар

- Компани бусад оролцогч, түүний дотор иргэний нийгмийн байгууллагатай янз бүрийн хувилбарууд, дараагийн хийх алхмаа ярилцах семинарыг хамтран зохион байгуулах буюу оролцож болно.

Нэр томъёо	Тодорхойлолт
Аккрүүл бүртгэл	Компанийн орлогыг орсон үед нь, зардлыг гарсан үед нь бүртгэхэд ихэвчлэн хэрэглэдэг бүртгэлийн систем. Энэ систем нь бэлэн мөнгө орж ирсэн эсвэл төлөгдсөн үед гүйлгээ хийсэн гэж үздэг бэлэн мөнгөний бүртгэлээс ялгаатай.
Захиргааны байгууллага буюу захирагч	Хүлээн авагч засгийн газар болон компанийн ирүүлсэн тайланг нэгтгэдэг буюу шинжилгээ хийдэг хараат бус бие даасан гуравдагч этгээдийг хэлнэ.
Аудит	Байгууллагын данс тооцоонд хараат бус этгээдийн хийдэг шалгалт.
Ашиг орлогын урсгал	Олборлох үйлдвэрээс хүлээн авагч засгийн газрын авдаг эдийн засгийн үр өгөөжийн боломжит эх үүсвэр. Эдийн засгийн шууд бус үр өгөөж болох барилга, дэд бүтэц, орон нутгийн хүмүүсийг ажлаар хангах зэргийг эдгээр тайлангийн хувьд ашиг орлогын урсгалд тооцохгүй.
Бэлэн мөнгөний бүртгэл	Засгийн газар голдуу хэрэглэдэг бүртгэлийн систем. ОСИТБС-ын тайланг энэ системээр гаргахыг зөвлөмж болгосон. Энэ систем нь бизнесийн байгууллагын хийсэн гүйлгээний зөвхөн бэлэн мөнгөөр хийсэн төлбөр болон орлогыг нь бүртгэдэг. Үүгээрээ орлогыг орсон, зарлагыг гарсан үед нь бүртгэдэг аккрүүл бүртгэлээс ялгаатай.
Олборлох салбарууд	Газрын хэвлийд буюу түүнд ойр байгаа байгалийн сэргээгдэшгүй баялагийг хайх, олборлоход оролцдог салбарууд. Байгалийн сэргээгдэшгүй баялаг гэж уг байсан газраа хүний гараар дахин бүтээж үл болох баялагийг хэлнэ.
ОСИТБС-ын тайлан	ОСИТБС-ын хэрэгжилтийн нэг хэсэг болгож захирагчийн бэлтгэсэн төлбөр болон орлогын тайлан.

Нэр томъёо	Тодорхойлолт
Хүлээн авагч орон	Хүлээн авагч засгийн газрын харъяаллаа тогтоосон нутаг дэвсгэрийн хил хязгаар, ямар нэг компани олборлох үйлдвэрлэл явуулах сонирхолтой байгаа нутаг дэвсгэрийг хэлнэ.
Хүлээн авагч засгийн газар	Нутаг дэвсгэрт нь олборлох салбарын компани үйл ажиллагаа явуулдаг төрийн засаглалын тогтолцоо ба байгууллага. Хүлээн авагч засгийн газарт эдгээр тогтолцооны орон нутаг, бүс, муж, холбооны төлөөлүүд, уг тогтолцоо, байгууллагуудын удирдлагад байдаг байгууллага, аж ахуйн нэгжүүд орох боловч дотоодын төрийн өмчит үйлдвэрийг оруулахгүй.
Олон улсын компани	Энэхүү гарын авлагын хувьд олон улсын компанид дараахь компанийг тооцно: <ul style="list-style-type: none"> • Өөрийнх нь төв компани байрладаг улсаас өөр нутаг дэвсгэрт олборлох салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн компани; • Өөрийг нь хянадаг засгийн газрын харъяа нутаг дэвсгэрээс гадуур үйл ажиллагаа явуулж байгаа улсын үйлдвэрийн газар.
Лиценз	Хүлээн авагч засгийн газар болон олборлох салбарын үйлдвэрлэлийн компани хоёрын хооронд тодорхой газар зүйн эсвэл геологийн газар нутаг болон ашигт малтмалын үйл ажиллагаатай холбогдуулан хийсэн зохицуулалт. Энэхүү гарын авлагын хувьд лиценз гэдэг нь мөн тодорхой хэмжээний газар нутаг эзэмших тусгай зөвшөөрөл гэсэн утгатай байна.
Дотоодын компани	Энэхүү гарын авлагын хувьд өөрийнх нь төв компани байрладаг улсын нутаг дэвсгэрт олборлох салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа улсын болон хувийн компанийг дотоодын компанид тооцно.

Нэр томъёо	Тодорхойлолт
Дотоодын төрийн өмчит компани	Хүлээн авагч оронд олборлох салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг, хүлээн авагч засгийн газрын хяналтанд байдаг компани. Хяналтад байдаг эсэхийг тодорхойлохдоо дараахь шалгуурыг ашиглана: Тухайн компанийн үйл ажиллагаанаас ашиг орлого олохын тулд түүний санхүү болон бизнесийн бодлогыг хүлээн авагч засгийн газрын зүгээс удирдах чадвар.
Төлбөрүүд	ОСИТБС-ын зорилгын үүднээс авч үзвэл компаниас засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг төлбөрүүдийг хэлнэ.
Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Хөрөнгө оруулагч этгээдэд ашигт малтмалын хайгуул хийх, боловсруулах, олборлох давуу эрхийг олгосны хариуд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тодорхой хувийг авах талаар хүлээн авагч засгийн газар, хөрөнгө оруулагч хоёрын хооронд байгуулсан гэрээ.
Тайлагнагч байгууллага	Тайлангийн маягыг бөглөж хүргүүлдэг компани, засгийн газар.
Тайлангийн маягт	ОСИТБС-ын хэрэгжилтийн нэг хэсэг болгон олон улсын ба дотоодын улсын үйлдвэрийн газар болон хүлээн авагч засгийн газраас захирагчид хүргүүлдэг маягтууд.
Орлогууд	ОСИТБС-ын зорилгын үүднээс газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниас засгийн газрын хүлээн авч байгаа бүх материаллаг орлого гэж тодорхойлно.
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	Ашигт малтмалын нөөцийг олборлохоос эхлээд цаашид нэмэлт боловсруулалт хийхгүйгээр зах зээлд гаргах шат хүртэлх уг ашигт малтмалыг олборлох, боловсруулах, үйлдвэрлэхтэй холбогдсон бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

Хавсралт

Тайлангийн маягтын жишээнүүд

Тайлангийн маягтын жишээнүүд

Эдгээр тайлангийн маягтыг 2003 онд ОСИТБС-д зориулан боловсруулсан. Бусад жишээ болон нэмэлт мэдээллийг <http://www.eitransparency.org/reportingguidelines.htm> гэдэг вэб сайтаас авна уу.

А. Хүлээн авагч засгийн газрын тайлагнагч байгууллагын орлогын маягт (газрын тос, байгалийн хий)

Хүлээн авагч орны тайлан

Тайлангийн хугацаа:

Хамрах хүрээ 1 Ашиг орлогын урсгал		
№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ №	Үнэ
1	Зөвхөн олон улсын компаниас орох ашиг орлогын урсгал	
1a)	Хүлээн авагч засгийн газрын бүтээгдэхүүний эрх i Олон улсын компаниас	
	а) Бүтээгдэхүүний урсгал-бэлэн бус	
	* [бүтээгдэхүүний болон нэгжийн нэрийг заа]	
	* [бүтээгдэхүүний болон нэгжийн нэрийг заа]	
	б) Бүт-ний урсгал-бэлэн мөнгөн	
2	Дотоодын улсын компанийн ашиг орлогын урсгал	
2a)	Хүлээн авагч засгийн газрын бүтээгдэхүүний эрх i Улсын үйлдвэрийн газраас	
	а) Бүтээгдэхүүний урсгал-бэлэн бус	
	* [Бүтээгдэхүүний болон нэгжийн нэрийг заа]	
	* [Бүтээгдэхүүний болон нэгжийн нэрийг заа]	
	б) Бүт-ний урсгал-бэлэн мөнгөн	

Хамрах хүрээ 1 Ашиг орлогын урсгал (үргэлжлэл)			
№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ №	Үнэ	
3 Олон улсын болон дотоодын УУГ-аас орсон ашиг орлогын урсгал			
3а) Ашгийн татварууд	iii		
3б) Нөөцийн төлбөр			
- бэлнээр			
- бэлэн бусаар			
3в) Ноогдол ашиг	v		
3г) Гэрээний болон үйлдвэрлэлийн урамшууллууд	vi		
3д) лицензийн төлбөр, түрээ, лиценз хөнгөлөхтэй холбоотой бусад зүйлс	vii		
3е) Хүлээн авагч ЗГ-т төлсөн бусад төлбөрүүд	viii		

Хамрах хүрээ 2 Ашиг орлогын урсгал			
№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ №	Үнэ	
4 Хамрах хүрээ 2 Ашиг орлогын гүйлгээнүүд (сайн дурын тайлан)			

Хүлээн авагч засгийн газрын гарын үсэг

Доорхоос бусад тохиолдолд, тайлангийн журмын заавар ёсоор тайлангийн маягтын үнэн зөв байдлыг бид хариуцахаа мэдэгдэж байна:

- _____
- _____
- _____

**Б Компаний тайлагнагч байгууллагын тайлангийн маягт
(газрын тос, байгалийн хий)**

Компаний нэр

Тайлагнаж буй хүлээн авагч орон:

Тайлангийн хугацаа:

Хамрах хүрээ 1 Ашиг орлогын урсгал		
№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ №	Үнэ
1 Зөвхөн олон улсын компанийн тайлагнах ашиг орлогын гүйлгээнд		
1а) Хүлээн авагч засгийн газрын бүтээгдэхүүний нэр, Хүлээн авагч засгийн газарт		
i) Бүтээгдэхүүний гүйлгээ-бэлэн бус		
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж		
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж		
ii) Бүтээгдэхүүний гүйлгээ-бэлнээр		
1б) Хүлээн авагч засгийн газрын УУГ-т олгосон бүтээгдэхүүний эрх		
i) Бүтээгдэхүүний гүйлгээ-бэлэн бус		
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж		
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж		
ii) Бүтээгдэхүүний гүйлгээ-бэлнээр		
2 Зөвхөн дотоодын УУГ-ын тайлагнах ашиг орлогын гүйлгээ		
2а) i) Дотоодын УУГ дахь засгийн газрын хувьцааны хэмжээ Засгийн газрын бүтээгдэхүүний нэр-бэлэн бус		
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж		
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж		
ii) Дотоодын УУГ дахь засгийн газрын хувьцааны хэмжээ, Засгийн газрын бүтээгдэхүүний нэр-бэлнээр		
2б) Дотоодын УУГ-ын хүлээж авсан бүтээгдэхүүний ашиг орлогын гүйлгээ-бэлэн бус		

Хамрах хүрээ 1 Ашиг орлогын урсгал			
№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ	№	Үнэ
2в) Дотоодын УУГ-ын бүтээгдэхүүний эрх	ii		
i) Бүтээгдэхүүний нэр-бэлэн бус			
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж			
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэг			
ii) Бүтээгдэхүүний нэр-бэлнээр			
2г) Засгийн газрын нэрийн өмнөөс хүлээж авсан бүтээгдэхүүний эрх	ii		
i) Бүтээгдэхүүний гүйлгээ-бэлэн бус			
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж			
* бүтээгдэхүүний гарал үүсэл, нэгж			
ii) Бүтээгдэхүүний гүйлгээ-бэлнээр	ii		
3 Засгийн газар болон дотоодын УУГ-т төлсөн төлбөрүүд			
3а) ашгийн татварууд	iii		
3б) нөөцийн төлбөрүүд	iv		
- бэлнээр			
- бэлэн бусаар			
3в) ноогдол ашиг	v		
3г) гэрээ, үйлдвэрлэлийн урамшууллауд	vi		
3д) лицензийн болон түрээсийн төлбөрүүд, лиценз хөнгөлөхтэй холбоотой бусад зүйлс	vii		
3е) засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	viii		

Хамрах хүрээ 2 Ашиг орлогын урсгал

№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ №	Үнэ
4	Хамрах хүрээ 2 Ашиг орлогын гүйлгээнүүд (сайн дурын тайлан)	

Удирдлагын гарын үсэг

Доорхоос бусад тохиолдолд, тайлангийн журмын заавар ёсоор тайлангийн маягтын үнэн зөв байдлыг бид захирлуудын зөвлөлийн нэрийн өмнөөс буюу түүнтэй адилтгах эрх бүхий байгууллагын нэрийн өмнөөс хариуцана гэдгээ мэдэгдэж байна:

- _____
- _____
- _____
- _____

В Компанийн нэгдсэн тайлангийн маягт (уул уурхай)

Тайлан хүлээн авагч орон:

Тайлангийн хугацаа:

Хамрах хүрээ 1 Ашиг орлогын урсгал

№	Зааврын 6-р хэсэг, Хэмжээ №	Үнэ
1 Олон улсын болон дотоодын УУГ-ын ашгийн гүйлгээ		
1а) ашгийн татварууд	i	
	ii	
1б) нөөцийн төлбөрүүд		
- бэлнээр		
- бэлэн бусаар		
1в) ноогдол ашиг	iii	
1г) гэрээ, үйлдвэрлэлийн урамшууллауд	vi	
1д) лицензийн болон түрээсийн төлбөрүүд	vii	
1е) засгийн газарт төлөх бусад төлбөрүүд (түүний дотор үйлдвэрлэлийн явцад төлсөн төлбөрүүд)	viii, v, vii	

